



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

АГУУЛГА

Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайлан

Хоёр. Хавсралтууд:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд биелэлт хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан / 145 хуудас/
2. Зам, тээврийн салбарын 2020 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, статистик мэдээлэл / 46 хуудас/
3. Байгууллагын шударга байдлын үнэлгээ /АТГ-аас үнэлгээг хийдэг/
4. ЗТХЯ-ны ил тод байдлын үнэлгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан / 3 хуудас/
5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайлан / 4 хуудас/
6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн биелэлт/ 21 хуудас/

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлангуудын жагсаалт:

1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2020.08.28-ны өдрийн 01/4023 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/,
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.01.20-ны өдрийн 03/428 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
3. 2020 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.01.20-ны өдрийн 01/252 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
4. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.01.29-ний өдрийн 03/249 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн/
5. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.03.31-ний өдрийн 01/1301 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
6. Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.03.31-ний өдрийн 01/1300 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /2021.01.15-ны өдрийн 01/187 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
8. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.03.01-ний өдрийн 01/791 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
9. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дотооддоо байнгын хяналт тавин ажилласан тайлангуудын жагсаалт:

1. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
2. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт
4. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт
5. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

2021.03.31

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/-ны 2020 оны үйл хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

Тайлант хугацаанд яамны 2020 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зам, тээврийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, СЗХ-наас гарсан шийдвэр, аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврууд зэрэг 20 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 107 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХЭГ, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газруудад тайлагнаж ажилласан. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилт:

Яамны 2020 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 178 арга хэмжээний 108 нь хэрэгжсэн, 47 нь 70%-ийн хэрэгжилттэй, 16 нь 40%-ийн хэрэгжилттэй, 3 арга хэмжээг давхардуулан төлөвлөж, 4 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон тул үнэлээгүй, хэрэгжилт **86.1** хувьтай байна.

ЗТХЯ-ны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт хавсаргав. /Хавсралт 1/

Яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрэгжүүлэх нэгж, хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

№	Нэгжийн нэр	Нийт заалт	Үүнээс /хувиар/						Биелэлт хувь
			100	70	40	0	Хассан	Давхардсан	
1	БТГ	36	27	6	3	-	-		90.0
2	ТЗУГ	15	5	8	2	-	-		76.0
3	ХШУДАГ	31	14	11	4	-	-		80.3
4	АЗБХЗГ	32	13	10	6	-	-		77.2
5	АТБХЗГ	13	5	5	1	-	2	1	80.9
6	ТЗДТБХЗГ	30	25	5	0	-	-	2	95.0
7	АТБХЗХ	21	19	2	0	-	2		97.1
НИЙТ		178	108	47	16	-	4	3	86.1

Хэрэгжилт хангалтгүй 40%-тай байгаа 16 арга хэмжээ:

1/ 1.1.2.7 “Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийг үргэлжлүүлэх” /БТГ, 1-4 улирал. Төслийн хэрэгжилтийг 63 хувьд хүргэх, загвар нэг төсөл эхлүүлсэн байна./
Биелэлт: Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийн 1, 2, 3 дугаар ажлын хэсэг болон мониторингийн цахим уулзалтыг Японы зөвлөхийн багтай хамтран 2020 оны 9-11-р сард зохион байгуулсан. Төслийн хүрээнд боловсруулсан Байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон асфальтбетон хучилт төсөллөх” болон “Дугуйн мөрний ховил тодорхойлох туршилтын арга” стандартын төсөлд олон нийт, мэргэжлийн холбоо, ААН-ээс санал авч, уг төсөлд тусгасан. Уг стандартын төслийг Авто замын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мэргэжилтний баг Японы туршлагад үндэслэн цементбетон хучилтын техникийн баримт бичгийг төсөллөж байна. Монголд ажиллах хүн/сарын хугацааг Японд ажиллах хугацаанд шилжүүлэн тооцож үзэхэд 2020 оны 11-р сарын байдлаарх төслийн явцын хувь 50.7% нь байна.

2/ 1.2.1.4 “Олон улс болон улсын чанартай авто замын ашиглалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах зорилгоор их засвар, шинэчлэлтийн ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” /АЗБХЗГ, 1-4 улирал. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.2 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл 35 хувьд хүрнэ. Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын аюулгүй байдлыг сайжруулах засварын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэсэн байна./
Биелэлт: АХБ-ны МОН-3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.2 км авто замын их засварын ажлын гүйцэтгээчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийн баримт бичгийн төслийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу боловсруулж, АХБ-нд хүргүүлсэн ба АХБ-аас тендерийн баримт бичгийн төсөлд 2020.02.16 өдөр зөвшөөрөл олгосон. Олгосон зөвшөөрлийн дагуу тендерийг 2020.02.21 өдөр зарласан. Тендерийг 2020.04.03-ны өдөр нээсэн. Үнэлгээний хороогоор тендерийн үнэлгээг гүйцэтгэж, үнэлгээний тайланг АХБ-нд 2020.05.19-ны өдөр хүргүүлсэн. АХБ-аас үнэлгээний тайланд 05 дугаар сарын 27-ны өдөр зөвлөмж, санал ирүүлсэн. Ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу тендерт оролцогчоос дахин тодруулга авах ажил хийгдэж, тайланг АХБ-нд 2020.08.11-ний өдөр дахин хүргүүлсэн. АХБ-аас 2020.08.18-ны өдөр үнэлгээний тайланд хариу ирүүлсэн ба дахин тендер зарлах зөвлөмжийг ирүүлсэн. АХБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дахин тендер зарлах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар шинэчилэн байгуулсан. Шинэчилсэн ажлын хэсгээр тендерийн баримт бичгийг дахин боловсруулж, АХБ-аас авсан зөвшөөрлийг үндэслэн дахин тендерийг 2020.10.28-ны өдөр зарласан. Тендерийг 2020.12.18-ны өдөр нээсэн.

-АХБ-ны МОН-3679 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын

аюулгүй байдлыг сайжруулах засварын ажлын зураг төслийг 2020.02.21-ний өдөр тус төслийн зөвлөх баг “Ай Си Ти” ХХК боловсруулж дуусгасан ба 2020.03.25-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр зарлаж, тендерийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр нээсэн. Үнэлгээний ажил хийгдсэн боловч АХБ-аас тендерийг хүчингүй болгож, дахин тендер зарлахыг зөвлөмж болгосон. АХБ-ны зөвлөмжийн дагуу дахин тендер зарлахаар холбогдох бэлтгэл ажлыг хангаж 12 дугаар сарын 04-ны өдөр зарласан.

3/ 1.2.1.5 “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжих, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааны үр өгөөжийг дээшлүүлэх, концессын гэрээгээр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх” /АЗБХЗГ. 1-4 улирал. Өмнөд Буйрын 21 дүгээр талбайгаас Тосон-Уул-Баянхошуу боомт чиглэлийн авто замтай холбох 58.5 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын бүрэн дуусч улсын ашиглалтад оруулсан байна. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс Цагаандэл Уул хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрнэ. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрнэ./

Биелэлт: Далан, хиймэл байгууламжийн ажил 100%, суурийн ажил 17%-ийг хийж гүйцэтгэсэн, цементээр бэхжүүлсэн суурийн материал холигч үйлдвэр, асфальтбетон завод суурьлуулсан. КОВИД-19-өөс шалтгаалан БНХАУ-аас цемент татахаар төлөвлөгдсөн ажил тасалдаж, цементийг дотоодоос очер дугаар үүсгэн бага хэмжээгээр татаж байгаа болон Захиалагчаас өнөөдрийг хүртэл гүйцэтгэл баталгаажуулаагүй, захиалагчийн хяналт орж ирэх боломжгүй болсон, санхүүжилт олгогдохгүй удсан зэргээс шалтгаалан ажил төлөвлөгдсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд Захиалагчаас нөхцөл байдлыг ойлгон гэрээт хугацааг сунгаахаар болсон байна. Барилын ажлын гүйцэтгэл 45%.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам: Зам барилгын ажил орон нутгийн зөвшөөрлөөс шалтгаалан удаашралтай байсан тул тус яамнаас Өмнөговь аймгийн Засаг даргын орлогчид дэмжлэг үзүүлж ажиллах талаар 01/3764 тоот хүргүүлсэн. 2020.10.12-ны өдөр Шадар сайд Я.Содбаатар авто зам, төмөр замын төслийн явцтай танилцаад, цаашид уялдаж ажиллах талаар үүрэг даалгавар өгсөн. Зам барилгын ажлыг 11 дүгээр сарын 18-ны өдөр зогсоосон. Талбайд хэмжилт, дурандлага, нүүлгэн шилжүүлэлт, хөрс хуулалт, ухмал, далангийн дүүргэлтийн ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 30%.

Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс Цагаандэл Уул хилийн боомт хүртэлх 270 км авто зам: Зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөлд шаардлагатай замын зурвас газар эзэмших зөвшөөрөл авахаар сум, орон нутагт хандсан боловч улс төржилтийн улмаас газар олгогдохгүй, саатаад байна. Тус яамнаас 2020.08.21-ний Өмнөговь аймгийн Засаг даргын орлогчид замын зурвас газрын зөвшөөрөл олгох, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх талаар 01/3893 дугаартай албан бичиг хүргүүлсэн. 2020.10.12-ны өдөр Шадар сайд Я.Содбаатар Тавантолгойн дэд бүтцийн бүтээн байгуулалттай /төмөр зам, авто зам/ танилцах үеэр замын ажил саатаад байгаа шалтгааныг танилцуулсан.

4/ 1.3.1.1 Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалтыг сайжруулах, батлуулах /АгТБХЗГ. 2 улирал. Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохын өмнө салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалтын бэлэн байдлыг хангаж, хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулна./

Биелэлт: Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулах, хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 10

дугаар сарын 28-ны өдрийн А/201 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг нь Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг батлуулж, хуулийн төсөлд 2020.11.03-ны өдрийн 01/ 5200 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авсан. Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэмжээнд боловсруулалт хийж, Сангийн яам болон Хууль зүй дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авах шатанд байна.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын тохируулагч агентлаг, үйлдвэрлэл үйлчилгээний чиг үүргийг тусгаарлах бүтцийн өөрчлөлтийг тусгасны дагуу салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалтын бэлэн байдлыг хангах, хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулах ажлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа албадын чиг үүргийг тусгаарлан, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 177 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяанд үйлдвэрлэл үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлэх Иргэний нисэхийн үндэсний төвийг байгуулан ажиллуулж байна.

5/ 1.3.3.1 “Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын шинэ төвийн барилга байгууламжийг хүлээн авах, агаарын навигацийн үйлчилгээний бэлтгэл ажлыг хангах” /АгТБХЗГ. 1-4 улирал. Бүсийн төвийн барилгын ажлыг хүлээн авсан байна. Барилгын ажлын гүйцэтгэл 100%, Тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлын явц 30%-д хүрсэн байна./

Биелэлт: Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгыг гэрээнд заасан хугацаандаа ашиглалтад оруулаагүй тул “Үүрэг трейд” ХХК-иас “Гэрээний үүргээ биелүүлээгүй, гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнд алданги гаргуулах тухай” нэхэмжлэлийг холбогдох баримт бичгийн хамт Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2020.04.03-ны өдөр гаргасан. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дээрх нэхэмжлэлийг хариуцагчийн оршин байгаа харьяаллын дагуу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Хэргийг шүүхээр хянуулах шатанд байгаа тул барилгын ажил ЗТХЯ болон ИНЕГ-аас хамаарахгүй шалтгаанаар зогссон. Анхан шатны шүүх хурал 2020.09.07-ны өдөр болж, “Үүрэг трейд” ХХК-иас хугацаа гаргаж өгөх, эвлэрэх санал шүүхэд гаргаснаар эцэслэн шийдэгдээгүй байна. Техник тоног төхөөрөмж худалдан авах тухай тендерийн баримт бичигт Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн албан тоотын дагуу өөрчлөлтийг оруулж, 2020.06.16-ны өдөр ИНЕГ/202002083 дугаар тендерийг зарласан. Тендерт оролцогчдын гомдлын дагуу Тендерийн баримт бичигт дахин холбогдох өөрчлөлтийг оруулж, баталгаажуулсан. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын шүүхийн маргаан эцэслэгдээгүй. Техник тоног төхөөрөмж худалдан авах ажлыг ИНЕГ-аас Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Тус газраас тендер зарлаж, 2021.01.06-ны өдөр тендерийг нээнэ.

6/ 2.1.2.1 “Нийтийн хэрэгцээнээс бусад замын хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн хуулийн төслийг боловсруулах” /АТБХЗГ. 1-4 улирал. Хуулийн төсөл боловсруулсан байна. /

Биелэлт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын алба Тээврийн цагдаагийн алба, АТҮТ ТӨҮГ хамтран “Нийтийн хэрэгцээний замаас бусад газарт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” эрх зүй, зам түүний байгууламж, тээврийн хэрэгслийн онцлогтой холбоотой судалгаа хийж, хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулан ЗТХ-ийн Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар ТЗУГ-т 11 дүгээр сарын 02 өдөр хүлээлгэн өгсөн.

7/ 2.1.2.2 “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журамыг хэрэгжүүлэх” /АТБХЗГ. 1-4 улирал. Программ хангамж боловсруулсан байна. Тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглаж эхэлсэн байна./

Биелэлт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журмыг хэрэгжүүлэхээр 11 байгууллагын төлөөлийг оролцуулсан ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2020 оны А/134 дүгээр тушаалаар байгуулж, Мэдээлийн сангийн өгөгдөл, техникийн шийдлийг гаргаж ЗТХ-ийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулахаар 10 дугаар сарын 13-ний өдөр ТЗУГ-т хүргүүлсэн. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журмыг хэрэгжүүлэхээр АНДБОЭЗК, АХБ-тай хамтарсан хурлыг 3 удаа зохион байгуулж техникийн туслалцаа үзүүлэх асуудлыг ярилцав. АХБ-ны "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах оролцогч байгууллагуудын чадавхийг сайжруулах төслийн хүрээнд Тээврийн цагдаагийн албанд ашиглаж байгаа ослын бүртгэлийн программ хангамжийг сайжруулах ажил хийсэн бөгөөд өнөөгийн байдлаар энэ программыг ЭМЯ, АТҮТ, Албан журмын даатгагчдын холбоотой хамтран ашиглаж байна.

8/ 2.3.2.2 “Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох” /АгТБХЗГ. 1-4 улирал. Зорчигч үйлчилгээний цогцолбор, бусад инженерийн байгууламжийн өргөтгөлийн ажлын гүйцэтгэл-100%. Зорчигч үйлчилгээний барилгын ажлын явц -30%/

Биелэлт: Иргэний нисэхийн ерөнхий газар болон "Некстстеп инженеринг" ХХК хооронд "Зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх болон бусад инженерингийн барилга байгууламжуудын ажлын зураг төсөл, төсвийг /Дорнод/ хийж гүйцэтгэх ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-07/19 дугаар гэрээг 2019.10.25-ны өдөр байгуулсан. Гүйцэтгэгч зураг төслийг гүйцэтгэж дуусган, Барилгын хөгжлийн төвөөр экспертизээр 2020.08.06-ны өдөр баталгаажуулж, ИНЕГ-ын даргын 2020.05.18-ны А295 дугаар тушаалаар байгуулсан комисс 2020.08.21-ний өдөр хүлээн авсан. Төсөвт өртөг 4.574 тэрбум төгрөгөөр хянагдаж баталгаажсан.

Нисэх буудлын аэродромын ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг боловсруулах ИНЕГ/ХОӨ/ТББ/Б-01/20 (88/20) тоот гэрээг 2020.08.03-ны өдөр байгуулж, 2020.09.22-ны өдөр аэродромын ерөнхий төлөвлөгөөг ИНЕГ-ын даргаар батлуулсан. Гүйцэтгэл 100%-тай байна.

“Чойбалсан” нисэх буудлын олон улсын 4С ангиллын шинэ аэродромтой болгох зураг төсөл, ажлын төсвийг гүйцэтгэсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн төвд хянагдах шатанд байна.

9/ 2.4.1.3. “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв” байгуулах” /АТБХЗГ. 4 улирал. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв”-ийн газрын асуудал шийдвэрлэгдсэн байна./

Биелэлт: Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв”-ийн газрын асуудалтай холбоотой асуудлаар 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эрх бүхий байгууллагаатай холбогдож санал солилцсон.

Мөн 2020 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн Хамтран ажиллах тухай 07/1051 тоот албан бичгийг “Олон улсын худалдаа, логистикийн төв” ХК-д хүргүүлсэн.

НЗДТГ-ын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэстэй ярьж тохирон “Олон улсын худалдаа, логистикийн төв”-ийн ТУЗ-ын хурал, НИТХ-аар оруулж шийдвэрүүлэхээр хүлээгдэж байна. Мөн Нийслэлийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд уг төвийн газрын асуудлыг тусгахаар холбогдох саналаа тус яамны БТГ-т 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн.

10/ 2.4.1.5. “Холимог тээврийн логистикийн төв, чингэлэг шилжүүлэн ачиж, буулгах ачааны терминал байгуулна” /АТБХЗГ. 1-4 улирал. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулагдсан байна./

Биелэлт: Тээврийн логистикийн төв, чингэлэг шилжүүлэн ачиж, буулгах ачааны терминал байгуулах ажлыг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэх саналыг 2020.03.31-ны өдрийн 04/20 тоот албан бичгээр Мейнлэнд блейк ХХК-иас ирүүлсэн. Сонирхогч аж аж ахуй нэгжүүдтэй санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн.



УУХҮС/ЗТХС-ын хамтарсан 2020.07.30-ны өдрийн А/198/А/139 тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Тавантолгойн уурхайд Нүүрс угаах, баяжуулах үйлдвэр, Дулааны цахилгаан станц, туузан дамжуулга, төмөр зам, автозам, логистикийн төв зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын объектуудын байршлын гадаргын төлөвлөлтийн төслийг боловсруулсан. Уг төлөвлөлтийг Засгийн газрын 2020.09.23-ны хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Логистикийн төвийг төмөр замын өртөө, баяжуулах үйлдвэр, ДЦС-тай хамтруулан байгуулахаар болсон.

Холимог тээврийн логистикийн төв, чингэлэг шилжүүлэн ачиж, буулгах ачааны терминал байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийн ажлын даалгаврын төсөлд тусгах саналаа 2020.09.15-ны өдрийн дотоод бичгээр Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Тус ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан 2020.10.18-ны өдрийн 03/478 тоот албан бичгээр Эрдэнэс Тавантолгой ХК-т хүргүүлсэн.

Логистикийн төв, ачааны терминал байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрдэнэс тавантолгой ХК-ны гүйцэтгэх захирал болон холбогдох мэргэжилтэнтэй холбогдож санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч холбогдох материалыг 2020.11.27-ны өдөр тус компанид цахимаар хүргүүлэв.

11/2.4.1.8 “Зам, тээврийн хөгжлийн яамны авто зогсоол дээр сэргээгдэх эрчим хүчээр ажиллах цахилгаан автомашин цэнэглэх зогсоол байгуулах” /АТБХЗГ 1-4 улирал. Нарны эрчим хүчээр цахилгаан автомашин цэнэглэх зогсоол байгуулагдсан байна./

Биелэлт: “Сэргээгдэх эрчим хүчний байгууламжийг гэрэлтүүлэх, халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх тухай туршилт, судалгаан”-ны ажлын хүрээнд “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ гүйцэтгэгчээр шалгарсан “Дүйнхэр тэргүүн” ХХК-тай 2020.11.15-ны өдөр гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлэв. Гүйцэтгэгч авто зогсоол дээр сэргээгдэх эрчим хүчээр ажиллах цахилгаан авто машин цэнэглэх цэг байгуулах ажлыг 2020 оны 12-р сард дуусган, 2021 оны 1-р сард туршилт хийж, захилагчид хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

12/ 2.4.2.1. “Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх” /АТБХЗГ. 1-4 улирал. Техникийн хяналтын үзлэгийн суурин төвүүд RFID шошго уншигч төхөөрөмжөөр хангагдсан байна./

Биелэлт: Нийслэлийн хэмжээнд RFID систем нэвтрүүлэхтэй холбоотойгоор 2020 оны төсөвт 600.0 сая төгрөг төсөвлөгдсөн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн А/28 дугаар тушаалаар “Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх”, “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан байгуулсан.

“АТУТ” ТӨҮГ-аас санал хүргүүлснээр RFID шошго уншигч төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг нийслэлийн Засаг даргын 2020 оны А/622 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Мэдээллийн технологийн газар зохион байгуулсан. Тус яамнаас “Техникийн хяналтын үзлэгийн талаар авах арга хэмжээний тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн А/161 дүгээр тушаалыг батлуулан хэрэгжилтийг хангуулан тухай бүр тайлагнаж ажиллах тухай чиглэлийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т мөн өдрийн 07/3886 дугаартай албан бичгээр хүргүүлж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 365 дугаар тушаалаар батлагдсан техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээг (RFID шошго бүхий загвар) хэвлүүлэх арга хэмжээ авах талаар үүрэг өгөгдсөн. “Ковид 19” цар тахлын улмаас санхүүгийн бэрхшээл тулгарсан тул Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн №01 дугаартай тогтоолын 5 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Албан журмын даатгагчдын холбооноос RFID системхийг хөгжүүлэх ажилд 2,0 тэрбум төгрөг зарцуулахаар шийдвэрлэсний дагуу хэрэгжилтийг хангуулах талаар тус яамны БТГ-аас төсөл боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн №14 дугаартай ажлын даалгаврыг батлуулан Албан журмын даатгагчдын холбоонд info@ami.mn хаягаар хүргүүлсэн. Мөн нийслэлийн Мэдээллийн технологийн газраас

зарласан худалдан авах ажиллагааны тендэрт 32 ширхэг RFID шошго уншигч төхөөрөмж худалдан авахаар оруулах тухай хүсэлтийг “АТҮТ” ТӨҮГ-ын 2020 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 3/1180 дугаартай албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн.

13/ 2.5.3.1. “Хөвсгөл нуурын усан замын төв зогсоолын зураг төслийг боловсруулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхэд оролцох” /ТЗДТБХЗХ. 1-4 улирал. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна./

Биелэлт: Энэхүү ажил нь 1-рт, Концессоор хэрэгжүүлэх /2-3 Засгийн газар дамжиж ирсэн/, 2-рт Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх гэсэн 2 хувилбараар явагдаж байгаа. Уг ажлыг Концессоор хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.117-д “... дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ” гэж заасан. Тус яам үүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол, түүний хавсралтаар батлагдсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д Засгийн газрын 2015 оны 133 дугаар тогтоолоор нэмэлт оруулж, уг жагсаалтын 1 дэх хэсгийн 7^д дэх заалтад Монгол Улсын аялал жуулчлалын гол бүс нутаг болох Хөвсгөл нуурын эрэгт усан замын төв буудал барьж байгуулах ажлыг тусгасан. Уг ажлыг сонгон шалгаруулах ажлын даалгаварыг боловсруулж, Хөвсгөл нуурын эрэгт барих газрыг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 1/542 тоот захирамжаар шийдвэрлүүлэн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 03/5520 тоот албан бичгээр концесс зарлуулахаар Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Үүнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрч, энэ хугацаанд амаар болон албан бичгээр удаа дараа шаардсан Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол барих концесс зарлах үедээ ажлын хэсэг байгуулна, түүнд танай яамны асуудал хариуцсан ажилтнуудыг татан оролцуулна гэсэн хариуг 2018 онд, концессын гэрээгээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэн ач холбогдлоор нь эрэмблэсний дагуу уг асуудал газрын төлөвлөгөөнд 2019 оны 3 дугаар улиралд тусгагдсан гэсэн хариуг тус газраас тухай бүр өгч байсан. Энэхүү ажлын концессыг зарлах арга хэмжээг зохион байгуулах тухай 03/1130 тоот албан бичгийг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр ҮХГ-т хүргүүлэв. Үндэсний хөгжлийн газраас концесс зарлах, зарлахгүй нь тодорхой болсон, мөн зарласан концесст эзэмшигч шалгарч гарч ирээгүй тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 дахь хувилбар буюу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 332 дугаар тогтоолоор баталсан Хөвсгөл нуур орчмын бүсийг “эко аялал, жуулчлалын бүс” болгон хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 800 сая төгрөгөөр Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол барих зураг төслийг боловсруулах ажлыг 2020-2021 онуудад гүйцэтгэнэ.

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол, түүний хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг Үндэсний хөгжлийн газраас шинэчлэн батлуулах гэж байгаатай холбогдуулан Хөвсгөл нуурын эрэгт усан замын төв буудал барих ажлын концесс зарлах ажил хойшилж байгааг тус газраас 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр мэдэгдсэн.

2. Засгийн газрын 2019 оны 332 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хөвсгөл нуур орчмын бүсийг “эко аялал жуулчлалын бүс” болгон хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 800 сая төгрөгийн санхүүжилт нь Зам, тээврийн хөгжлийн сайдын багцаас гарах бөгөөд уг хөрөнгийг сайдын багцад тусгаж Сангийн яаманд 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/3768 тоот албан бичгээр БТГ-аас хүргүүлсэн.

14/ 3.2.1.1” Иргэний нисэхийн багц дүрмийн төслийг хянаж, батлуулах” /АгТБХЗХ 1-3 улирал 10 дүрмийг батлуулж, нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

Биелэлт: ИНЕГ-аас 13 дүрмийн төслийг боловсруулан, батлуулахаар ирүүлснийг хянан үзэхэд дүрмийн төсөлд тусгагдсан “Нисэхийн аюулгүй ажиллагаа”, “аюулгүй байдал” гэх нэр томъёо нь Иргэний нисэхийн тухай хуульд зааснаас өөр тайлбартай байсан тул иргэний нисэхийн дүрмийн төслийг дахин нягталж, боловсруулах чиглэлийг 2020.04.23-ны өдрийн 01/1830 тоот албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн.



ИНЕГ-аас 2020.07.23-ны өдрийн 09/3354 тоот албан бичгээр 13 дүрмийн төслийг боловсруулан, батлуулахаар ирүүлснийг хянан үзэхэд дүрмийн төсөлд тусгагдсан “Нисэхийн аюулгүй ажиллагаа”, “аюулгүй байдал” нэр томъёоны зөрүүг арилгах тухай чиглэлийг дахин хүргүүлсэн. ИНЕГ-аас 2020.08.26-ны өдрийн 01/2244 тоот албан бичгээр дахин 13 дүрмийн төсөл ирүүлснийг хянан үзэж 2020.10.12-ны өдрийн 09/4814 тоот албан бичгээр Хуулийн хэлстээс өгсөн чиглэлийн дагуу багц дүрмийн төслийг дахин боловсруулж ирүүлэх чиглэлийг өгсөн.

15/ 3.3.1.3. “Цахилгаан тээврийн хэрэгсэл болон сэлбэг эд ангийг гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл боловсруулах” /АТБХЗГ. 1-2 улирал. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн байна. /

Биелэлт: Олон Улсын Валютын Сантай байгуулсан гэрээ 2020 оны 3-р улиралд дуусгавар болсон тул хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин боловсруулан Сангийн сайдтай зөвшилцөж батлуулахаар ЗТХС-ын 2020 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 01/4412 дугаар бичгээр хүргүүлэв. Хууль тогтоомжийн тухай хуулийн “15-р зүйлийн 15.3 дахь хэсэгт Засгийн газрын санаачлах хуулийн төслийн үзэл баримтлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага боловсруулна” гэж заасан тул гааль, татварын бодлого Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарах тул дэмжих боломжгүй талаа Сайнгийн сайдаас 2020 оны 6/6617 дугаар хариу ирүүлэв. Мөн Сангийн сайд тус яамны удирдлагатай уулзах үеэр аж ахуйн нэгжүүдэд татварын тодорхой хөнгөлөлт үзүүлж байгаа тул хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн төсөл боловсруулахгүй байх чиглэл өгсөн байна.

16/ 3.3.1.5. “Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэр байгуулах” /АТБХЗГ. 1-4 улирал. Дахин боловсруулах үйлдвэрийг байгуулсан байна. /

Биелэлт: Ашигт малтмал, газрын тосны газар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 7 дугаар 1-ний өдрийн БЧ-2020-02-04 дугаар дүгнэлт гарч Налайх дүүрэгт ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэр байгуулах ТЭЗҮ батлагдсан. Батлагдсан ТЭЗҮ-ийн хүрээнд “Монгол авто ресайкл” ХХК байгаль орчны үнэлгээ хийлгэн барилга угсралтын ажлыг эхлүүлэх мэргэжлийн байгууллагуудаас зөвшөөрөл авсан. Төсөл хэрэгжүүлэгч корона вирусын цар тахлаас шалтгаалан хөрөнгө оруулагч Монгол Улсад орж ирж чадахгүй байгаа тул 2021 оны 4-р сарын 15-аас үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээ мэдэгдээд байна.

2.2. Монгол Улсын Тогвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ийн хэрэгжилт:

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д I үе шат буюу 2020 он хүртэл Зам, тээврийн хөгжлийн сайдын дангаар 2 зорилтыг хэрэгжүүлэх 14 арга хэмжээ, УУХҮЯ, ЭХЯ-тай хамтран хэрэгжүүлэх 1 зорилт, арга хэмжээ тусгагдсан. Салбар тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Төмөр зам	Авто зам	Агаарын тээвэр	Автомтээвэр	Логистик, бодлого
3	1	5	1	4
70%-1	100%	88%	100%	100%-2,
Үнэлэх боломжгүй-2				Үнэлэх боломжгүй-2

Зам, тээврийн хөгжлийн сайдын үндсэн хэрэгжүүлэх 14 арга хэмжээний хэрэгжилтийг 2020 оны байдлаар авч үзвэл үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 8, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 1, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 1, үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байна. Хэрэгжилт дунджаар **91.0** хувьтай байна.

Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 1 зорилт, арга хэмжээ 100%-ийн хэрэгжилттэй байна.

Дараах 4 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна. Үүнд:

3.2. Хөшгийн хөндийд ложистикийн төв байгуулах /Шинээр байгуулах ложистикийн төвийн тоо 1/

3.3. Алтанбулагт ложистикийн төв байгуулах /Шинээр байгуулах ложистикийн төвийн тоо 1/

3.6. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх /Барилгын ажлыг эхлүүлсэн байна/

3.7. Богд хан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх /Барилгын ажлыг эхлүүлсэн байна/

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн биелэлттэй дараах 1 арга хэмжээ байна.

4.4. Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, ЗС ангилалын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай болгох /Барилгын ажлын явц, хувиар 100%/

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2020.08.28-ны өдрийн 01/4023 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

2.3. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 96 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020-2021 онд хэрэгжүүлэх 56 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт дунджаар **84.6** хувьтай байна.

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	90	70	50	30	0	Хувь
1	АЗБХЗГ	24	10	5	6	3	-	-	84.2
2	АгТБХЗГ	14	3	5	4	2	-	-	80.7
3	АТБХЗГ	4	1	2	1	-	-	-	87.5
4	ТЗДТБХЗГ	8	5	2	1	-	-	-	93.7
5	ТЗУГ	1	-	1	-	-	-	-	90
6	БТГ	5	1	1	3	-	-	-	80
Нийт		56	20	16	15	5	-	-	84.6

Дараах шалтгааны улмаас 50 хувийн биелэлттэй дараах 5 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Авто замын чиглэлээр:

1/ 3.6.1.6.3. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барина. /Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь/



Биелэлт: Орон нутгаас замын зурвас газрын зөвшөөрөл олгогдоогүй учир зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Тус яамнаас 2020.08.21-ний Өмнөговь аймгийн Засаг даргын орлогчид замын зурвас газрын зөвшөөрөл олгох, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх талаар 01/3893 дугаартай албан бичиг хүргүүлсэн. 2020.10.12-ны өдөр Шадар сайд Я.Содбаатар Тавантолгойн дэд бүтцийн бүтээн байгуулалттай /төмөр зам, авто зам/ танилцах үед замын ажил саатаад байгаа шалтгааныг танилцуулсан.

2/ 6. Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замыг барина./Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь/

Биелэлт: КОВИД-19 цар тахлаас шалтгаалан концесс эзэмшигч, гадаад ажиллах хүч оруулах ажил оройтсоноос зам барилгын ажил эхлээгүй. Засгийн газрын 2020.05.06-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор батлагдсан квот, хуваарийн дагуу 2020.09.16-ны өдөр 15 хятад мэргэжилтэн орж ирэн 21 хоногийн тусгаарлалтад орсон, 10 дугаар сарын 07-ны өдөр тусгаарлалтаас гарч, зураг төсөвтэй холбоотой хэмжилт, тооцоо судалгаа, карьерын байршил тогтоох зэрэг бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн.

3/ 3.6.1.10.3. Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын голын 36.8 у/м төмөрбетон гүүрийг барина. /Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь/

Биелэлт: 2020 онд Улсын төсөвт тусгагдсан 200 сая төгрөгийг бүрэн зарцуулж дууссан. Нийт ажлын явц 15%-тай байна. Үлдсэн хөрөнгөө 2021 оны төсөвт суугдсан.

Агаарын тээврийн чиглэлээр:

4/ 3.6.3.2.5. Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийнэ. /Ховд аймгийн Булган нисэх буудлуудын аэродромын их засварын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ./

Биелэлт: Ховдын Булган, Хэнтийн Дадал сумын нисэх буудлын аэродромын их засварын ажлын “Ажлын даалгавар”-ыг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

5/ 8. Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлыг зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, дуусган ашиглалтад оруулна. /Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь/

Биелэлт: Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолбор барих гүйцэтгэгчээр “Биг монголиа билдинг” ХХК шалгарч, ЗТХЯ-тай “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Дадал сумын “Дэлүүнболдог” нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум/ ажил гүйцэтгэх гэрээ”-г 2020.06.19-ний өдөр байгуулсан. Гэрээт ажлын явц зураг төсөл боловсруулах шатанд байна. 2021 оны улсын төсөвт зорчигч үйлчилгээний цогцолборыг барих санхүүжилт 5 тэрбум төгрөг тусгагдсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2021.01.20-ны өдрийн 03/428 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 36 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Зам, тээврийн салбарт 5 зорилтыг хэрэгжүүлэх нийт 50 арга хэмжээний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл дунджаар **92.5** хувийн биелэлттэй үнэлэгдлээ. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилт **91.4** хувийн биелэлттэй үнэлэгдлээ. Хэрэгжилтийг давхардсан тоогоор газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	90	70	50	30	0	Санхүү- жилтгүй	Хувь
1	АЗБХЗГ	41	23	13	3	-	1	-	1	92.7
2	АгТБХЗГ	3	-	-	-	-	-	-	3	-
	ИНЕГ	3	-	-	-	-	-	-	3	-
3	АТБХЗГ	3	2	-	-	-	-	-	1	100
4	ТЗДТБХЗГ	5	2	-	1	-	-	-	2	90
5	“МТЗ” ТӨХК	2	-	-	1	-	-	-	1	70
6	“Нортерн рейлвейс” ХХК	1	-	-	-	-	-	-	1	-
7	БТГ	2	2	-	-	-	-	-	-	100
Нийт		50	25	13	4	-	1	-	7	92.5

Үүнээс 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажилласан боловч төсвийн тодотголоор хасагдсан, төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр гадны хөрөнгө оруулагч санхүүгийн байгууллагуудад хүсэлт хүргүүлж, санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байгаа тул үнэлээгүй болно. Харин 30 хувийн биелэлттэй дараах 1 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

7.1.39. “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлэх” /АЗБХЗГ, 30%/

Биелэлт: Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замд их засвар хийх ажлыг АХБ-ны МОН-3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ба зураг төслийг 2019 оны 09 дүгээр сард боловсруулж дууссан. Их засварын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах 2 багц бүхий олон улсын тендерийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу 2020.02.24-ны өдөр зарласан. Тендерийг 2020.04.03-ны өдөр нээсэн. Тендерийн үнэлгээний эцсийн тайланг 2020.08.11-ний өдөр АХБ-нд хүргүүлсэн. АХБ-аас үнэлгээний тайланг хянан үзэж, тендерийг хүчингүй болгож дахин тендер зарлах зөвлөмжийг 2020.08.18-ны өдөр ирүүлсэн. АХБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дахин тендер зарлах үнэлгээний хороог ТНБД-ын тушаалаар шинэчилэн байгуулсан. Шинэчилсэн ажлын хэсгээр тендерийн баримт бичгийг дахин боловсруулж, АХБ-аас авсан зөвшөөрлийг үндэслэн дахин тендерийг 2020.10.28-ны өдөр зарласан. Тендерийг 2020.12.18-ны өдөр нээсэн. Үнэлгээ хийгдэж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2021.01.20-ны өдрийн 01/252 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.5. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын шилжин хэрэгжих 18, шинээр хэрэгжүүлэх 6 арга хэмжээг 2020 оны жилийн эцсийн байдлаар үнэллээ. Шилжин хэрэгжүүлэх арга хэмжээ 88.7%, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ 85%, нийт арга хэмжээний хэрэгжилт дунджаар **87.7** хувьтай байна.

Нийт арга хэмжээг салбар тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Төмөр зам	Авто зам	Агаарын тээвэр	Автотээвэр	Логистик, бодлого
3	16	2	1	2



100%	87.3%	95%	100%	65%
Санхүүжилтгүй-1	Санхүүжилтгүй-1			

Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 24 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл 2020 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 15, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 4, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Санхүүжилтгүй хэрэгжих боломжгүй 2 арга хэмжээг үнэлээгүй болно.

30 хувийн биелэлттэй дараах 2 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөл”
Биелэлт: 2018 он: Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад “Шууд гэрээ байгуулах”-аар тусгасан. Мөн ЗГ-ын 2018.05.23-ны 153 дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. Иймээс уг төмөр замтай зэрэгцүүлэн хүнд даацын цементбетон хучилттай 500 км авто зам барих нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн. Харин эхний ээлжид Тавантолгойн нүүрсийг экспортлох шинэ гарц бий болгох, коксжих нүүрсээ Бугатын төмрийн үйлдвэр буюу эцсийн хэрэглэгчид шууд хүргэх боломжтой Тавантолгой-Ханги чиглэлийн хүнд даацын авто замын төслийг хэрэгжүүлэх нь улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөхөөс гадна замын барилгын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтаа зам ашигласны хураамжаас нөхөх боломжтой. Оюутолгой болон бусад замын дагуух уурхайнууд уг замын төслийг дэмжиж байна гэдгээ илэрхийлээд байгаа.

2019 он: Засгийн газрын 2018.10.31-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг Үндэсний хөгжлийн газарт олгосний дагуу 2019.03.29-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг ханган, холбогдох материалыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сард эрх бүхий этгээдээс гэрээ хүчин төгөлдөр болсныг баталгаажуулсан.

2020 он: Концесс эзэмшигчээс авто замын барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлснийг хянаж үзээд шаардлага хангасан тул 2020.06.18-ны өдөр 06/14/2020 дугаартай “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл” олгосон.

Гүйцэтгэгчээр “Өндөр Алтайн зам” ХХК, “Дарданговь” ХХК, “Мотор сервис” ХХК-ууд ажиллаж байна. Зам барилгын ажлыг 2020.06.18-ны өдрөөс эхэлж 2020.11.18-ны өдөр зогсоосон. Талбайд хэмжилт, дурандлага, нүүлгэн шилжүүлэлт, хөрс хуулалт, ухмал, далангийн дүүргэлтийн ажил хийгдсэн. КОВИД-19 цар тахлаас шалтгаалан ажил саатсан. Зам барилгын ажлын гүйцэтгэл 12%-тай.

“Тяньжин тээвэр логистикийн төв байгуулах төсөл”

Биелэлт: 2018 он: МУ-ын Зам, тээврийн хөгжлийн яам болон БНХАУ-ын Тяньжин хотын Ардын Засгийн газар хооронд Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичгийг 2018 оны 05 дугаар сард албан шугамаар шинэчлэн байгуулсан.

2019, 2020 он: Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу Тяньжин хотод шинээр байгуулагдах “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн бүс” ХХК-д хөрөнгө оруулж 49 хувийн хувьцааг эзэмших, хамтран ажиллах эрхийг “Монголиан порт групп” ХХК-д олгох асуудлыг 2019.04.17-ны өдөр Монгол улсын Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, тэмдэглэл гарсан.

БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд тээвэр, логистикийн үйл ажиллагаа эрхлэх зориулалттай Монголын талын 49 хувь, Хятадын талын 51 хувийн хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулах ЗГ-ын 164 дүгээр тогтоол 2019.04.23-ны өдөр гарсан.

Энэхүү Засгийн газрын тогтоолын дагуу 05.26-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл нь “Тяньжин порт (групп)” ТӨХК-ийн охин компани болох “Тяньжин портын эдийн засаг, техник технологийн хамтын ажиллагаа” ХХК-тай “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-а байгуулах хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Мөн 05.27-ны өдөр “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-ийн ТУЗ-ийн анхдугаар хурал хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Гүйцэтгэх захирал, Дэд захирлыг томилсон.

2019.06.27-ны өдөр “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-ийг БНХАУ-ын (Тяньжин) чөлөөт худалдаа туршилтын бүс зах зээлийн хяналт, зохицуулалтын газар-т бүртгүүлэн компанийн гэрчилгээг авсан.

2019 оны 07 дугаар сард “Монголиан порт групп” ХХК-аас Монголын талын хөрөнгө оруулалтын эхний хэсгийг “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-д байршуулсан.

“Монголиан порт групп” ХХК-аас Монголын талын хөрөнгө оруулалтын дараагийн хэсгийг “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-д байршуулахаар яаравчлан ажиллаж байна.

2018 оны 12 дугаар сард Тяньжин хотын Олон Улсын инженерингийн зөвлөх компаниас Тяньжин тээвэр логистикийн төв төслийн ТЭЗҮ-ийн саналын төслийг “Монголын төмөр зам” ТӨХК-д ирүүлсэн бөгөөд ТЭЗҮ-шинэчлэсэнтэй холбогдуулан 01.18-ны өдөр МТЗ ТӨХК болон МУУХМ ХХК-ийн хамтарсан Ажлын хэсэг байгуулагдсан. Шинэчилсэн ТЭЗҮ-ийг хамтарсан Ажлын хэсэг авч хэлэлцэн ТЭЗҮ-д өгөх саналыг боловсруулан 2019.02.25-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл болон холбогдох төлөөлөгчид Тяньжин хотноо айлчлах үеэр Тяньжин порт групп-ын удирдлагуудад албан бичгээр хүргүүлсэн.

Мөн 2019.03.04-ний өдөр Тяньжин хотын Олон Улсын инженерингийн зөвлөх компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийн дэлгэрэнгүй танилцуулгыг хийж, Монголын талаас хэд хэдэн тодруулга асуулт тавьсны зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүнийг Хятадын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд байгаль орчны нөлөөлөлд тавигдах шаардлага, төслийн санхүүгийн загварчлалын талаарх мэдээллийг Монголын талд гаргаж өгөхийг хүссэн.

Хамтарсан Ажлын хэсгийн тавьсан асуудлын дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хөнгөлөлттэй бодлогын тарифыг тусгаж ТЭЗҮ-ийн санхүүгийн тооцоололд өөрчлөлт оруулахаар болсон. Дэлхий нийтийг хамарсан цар тахал/Covid-19/-ын улмаас төслийн ажил зогсонги байдалтай байна.

Санхүүжилтгүй хэрэгжих боломжгүй 2 арга хэмжээг үнэлээгүй болно. Үүнд:

“Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.3 км төмөр замын төсөл” /Төслийн ажлын явц 100 хувь, Барилга угсралтын ажлыг дуусгана/

Биелэлт :2018 он: Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг ЗГ-ын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан.

БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг “МАК” ХХК “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчлүүлсэн.

Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын геологи, геодези, археологи, палентологийн судалгаанууд болон Техникийн зураг төслийг боловсруулсан.

“МАК” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Өмнийн говийн элс” ХХК, “Чинхуа МАК Нарийнсухайт” ХХК нар хамтран “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг байгуулсан.

“Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2018.08.01-ний өдрийн 232 тоот тогтоолоор “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай

хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг даалгасан.

Тус чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаагаас төмөр замын ажил зогсонги байдалд орсон.

2019 он: Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг бүрэн боловсруулж дууссан бөгөөд царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. Цариг шийдвэрлэгдээгүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар 2014 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гарч буцаан татсан. Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолоор Шивээхүрэн-Сэхэ боомт хооронд 13 км төмөр зам барих тухай шийдвэр гарсан хэдий ч тухайн төмөр замын царигийн өргөний хэмжээ тодорхойгүйгээс барилгын ажил эхлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

2020 он: Үндсэн хуулийн цэцийн 2020.05.13-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгож УИХ-ын 2020.05.15-ны өдрийн 57 дугаар тогтоол батлагдсанаар тус чиглэлийн төмөр замын царигийн хэмжээг тодорхойлж өгсөн. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.5 км төмөр замын барилгын ажлыг 2023-2024 онд эхлүүлэхээр тусгуулсан.

Мөн Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд Шивээхүрэн-Сэхэ боомтыг төмөр замын ангиллаар олон улсын зэрэглэлтэй байнгын ажиллагаатай байх саналыг ГХЯ-д хүргүүлж, 2020.09.15-ны өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичиг” солилцох замаар энэхүү хэлэлцээрийг албажуулсан. Цаашид санхүүжилт шийдвэрлэгдсэнээр энэхүү чиглэлийн боомт орчмын төмөр замыг барих нөхцөл бүрдэнэ.

“Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам” /Төслийн ажлын явц 40 хувь, Төслийн бэлтгэл ажлыг хангана/

Биелэлт: 2018 он: Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2017.06.14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу ҮХГ-аас 2017.08.16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017.10.16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн.

Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018.01.16-ны өдөр баримт бичгийг олгож эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018.04.19-ний өдрийн 11.00 цагт нээсэн боловч нэг ч санал ирээгүй болно.

2019, 2020 он: Уралдаант шалгаруулалтад шаардлага хангасан төслийн санал ирээгүй тул концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах нөхцөл бүрдсэн. Үндэсний хөгжлийн газраас концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах шууд гэрээний урилгыг 2019.09.30-ны өдөр хүртэл хүлээн авахаар 2019.08.30-ны өдөр цахим хуудсандаа байршуулсан боловч санал ирээгүй. Иймд тус төслийг цаашид концессоор хэрэгжүүлэхэд дахин төслийн санал ирүүлэх магадлал бага байгаа тул хөрөнгө оруулалтын өөр хэлбэрээр хэрэгжүүлэх



боломжийг судлаж үзэхийг хүссэн 01/3163 дугаартай албан тоотыг Үндэсний хөгжлийн газраас тус яаманд ирүүлсэн. Санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна.

Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2021.01.29-ний өдрийн 03/249 тоот албан бичгээр “Үндэсний хөгжлийн газар”-т хүргүүлсэн.

2.6. Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилт:

Зам, тээврийн салбарт УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого”, УИХ-ын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” /2018-2026/ гэсэн 3 бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээрийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Батлагдсан хугацаа	Тогтоолын дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	2020 оны үнэлгээ	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
1	“Төрөөс төмөр замын тэврийн талаар баримтлах бодлого”	2010.06.24	УИХ №32	хугацаагүй	78,3%	байхгүй
2	“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”	2013.02.07	УИХ №18	2013-2020	74,1%	байхгүй
3	“Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”	2018.10.24	ЗГ №321	2018-2026	57,1%	30,6%

Зам, тээврийн салбарын Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2021.03.31-ний өдрийн 01/1300 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.6.1 “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын хэрэгжилт:

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д “Олон улсын стандарт шаардлагад нийцсэн нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангасан эдийн засгийн үр ашигтай, өрсөлдөх чадвар бүхий иргэний нисэхийн үйлчилгээг бий болгож, улс орны эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх” зорилгын хүрээнд нийт 12 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 428 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 172 дугаар тушаалаар тус тус “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх” 2 төлөвлөгөө баталсан бөгөөд нийт 118 арга хэмжээ хэрэгжүүлэхээр заасан байна.

Энэхүү 2 төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар дүгнэж үзэхэд 100%-ийн хэрэгжилттэй 53 арга хэмжээ, 90%-ийн 4 арга хэмжээ, 70%-ийн хэрэгжилттэй 32 арга хэмжээ, 50%-ийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 13 арга хэмжээ,

0%-ийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ, хэрэгжилт **74,1** хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. Хэрэгжилтийг зорилтоор нь ангилан авч үзвэл:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	1.2.1 Монгол Улсын иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	22	12	0	5	2	1	2	76.4%
2	1.2.2. аялал жуулчлалыг дэмжсэн иргэдийн хэрэгцээг хангасан, эрэлтэд нийцэхүйц, хүртээмжтэй агаарын тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийн зохицуулалтыг бий болгох	25	9	0	9	3	4	0	72%
3	1.2.3. Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын зөвлөмжийн дагуу иргэний нисэхийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангахуйц бүтцийн шинэчлэл хийх	7	1	1	4	0	0	1	67.1%
4	1.2.4. иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийн шинэчлэлтийг тогтмол хийх	7	4	2	1	0	0	0	92.8%
5	1.2.5. салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх	9	8	0	1	0	0	0	96.7%
6	1.2.6. нисэх буудлуудын дэд бүтцийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх	19	2	0	5	2	7	3	45.3%
7	1.2.7. үндэсний агаарын тээвэрлэгчийг олон улсын зах зээлд бусад улсын агаарын тээвэрлэгчтэй өрсөлдөхөд бэлтгэх, түүний үнэлэмжийг дээшлүүлэх; 1.2.10. агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг үе шаттайгаар, төрийн хяналт, зохицуулалттайгаар бий болгох.	5	2	0	3	0	0	0	82%
8	1.2.8. агаарын навигацийн үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бодлого, чиг хандлагад нийцүүлэх	7	6	0	0	0	0	1	85.7%

9	1.2.9. ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх	3	2	0	0	1	0	0	83.3%
10	1.2.11. иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудад хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих	1	0	0	1	0	0	0	70%
11	1.2.12. дотоодын агаарын тээврийн үйлчилгээг алсагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүргэхэд чиглүүлэх	12	6	1	3	1	1	0	81.7%
12	Бусад	1	1	0	0	0	0	0	100%
Нийт		118	53	4	32	9	13	7	74.1%

Хэрэгжилтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагаар нь /давхардсан тоогоор/ авч үзвэл:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/						Биелэлт хувь
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	ЗТХЯ	114	50	4	31	9	13	7	73.4%
2	ЗГХЭГ	3	2	-	-	1	-	-	83.3%
3	СЯ	16	11	-	3	-	2	-	85.6%
4	ХЗДХЯ	8	3	-	3	2	-	-	76.3%
5	БОАЖЯ	1	-	-	-	-	1	-	30.0%
6	БХЯ	2	2	-	-	-	-	-	100.0%
7	ГХЯ	10	4	-	4	-	2	-	74.0%
8	БХБЯ	2	1	-	-	1	-	-	75.0%
9	ХНХЯ	1	1	-	-	-	-	-	100.0%
10	УУХҮЯ	3	1	-	1	-	1	-	66.7%
11	СЗХ	2	-	-	1	1	-	-	60.0%
12	СХЗГ	7	4	2	1	-	-	-	92.9%
13	ОБЕГ	1	1	-	-	-	-	-	100.0%
14	ҮХГ	11	6	-	2	1	2	-	77.3%
15	ТӨБЗГ	5	4	-	1	-	-	-	94.0%
16	ЗХЖШ	1	1	-	-	-	-	-	100.0%
17	ИНАБЗ	1	1	-	-	-	-	-	100.0%
18	ИНЕГ	105	46	4	29	8	12	6	73.8%
19	НТОЗШША	5	1	-	3	1	-	-	72.0%
20	МИАТ	4	2	-	1	-	-	1	67.5%
21	АТБ	32	14	-	11	3	3	1	75.3%
22	ИНТББ	8	4	-	1	3	-	-	77.5%
23	ИНУБ	1	-	-	1	-	-	-	70.0%
24	ТХХТ	1	1	-	-	-	-	-	100.0%
Нийт		118	53	4	32	9	13	7	74.1%

2.6.2. “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилт:

“Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” /2018-2026/-ыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор баталсан ба түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 286 дугаар тушаалаар баталсан.

Уг төлөвлөгөөнд бодлогын 8 чиглэлийн хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”/2018-2026/-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг чиглэлээр нь авч үзвэл:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Мэргэжил, ур чадварт тулгуурласан орчин үеийн хүний нөөцийн менежменттэй хослуулсан өрсөлдөх чадвар бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр	10
2.	Чанартай, хүртээмжтэй, хосолсон тээврийн дэд бүтцийг бий болгох замаар олон улсын тээврийг хөгжүүлэх чиглэлээр	16
3.	Тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	27
4.	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд тулгуурласан, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнс, өргөн хэрэглээний барааны дотоодын тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр	17
5.	Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	21
6.	Тээвэрлэлтийн болон авто замын сүлжээний аюулгүй байдлын цогц менежментийг хөгжүүлэх чиглэлээр	20
7.	Техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	10
8.	Автотээврийн салбарын хөгжлийг судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн тодорхойлж, автотээврийн салбарын инновацийг хөгжүүлэх чиглэлээр	7
НИЙТ		128

Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 128 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2020 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн хэрэгжилттэй 24, 90%-ийн хэрэгжилттэй 6, 70%-ийн хэрэгжилттэй 30, 50%-ийн хэрэгжилттэй 12, 30%-ийн хэрэгжилттэй 31, 0%-тай буюу хэрэгжээгүй 12, хугацаа болоогүй 13 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **57.1** хувьтай байна.

Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилан авч үзвэл:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар							Нийт хувь
			100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
1	Мэргэжил, ур чадварт тулгуурласан орчин үеийн хүний нөөцийн менежменттэй хослуулсан өрсөлдөх чадвар бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр	10	2	2	2	-	3	-	1	67.8

2	Чанартай, хүртээмжтэй, хосолсон тээврийн дэд бүтцийг бий болгох замаар олон улсын тээврийг хөгжүүлэх чиглэлээр	16	2	-	3	2	4	2	3	48.5
3	Тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	27	3	2	5	4	10	2	1	51.2
4	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд тулгуурласан, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнс, өргөн хэрэглээний барааны дотоодын тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр	17	1	-	2	-	1	7	6	24.5
5	Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	21	5	-	7	1	6	1	1	61.0
6	Тээвэрлэлтийн болон авто замын сүлжээний аюулгүй байдлын цогц менежментийг хөгжүүлэх чиглэлээр	20	3	1	6	3	7	-	-	58.5
7	Техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	10	3	-	4	2	-	-	1	75.5
8	Автотээврийн салбарын хөгжлийг судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн тодорхойлж, автотээврийн салбарын инновацийг хөгжүүлэх чиглэлээр	7	5	1	1	-	-	-	-	94.3
Нийт		128	24	6	30	12	31	12	13	57.1

2.6.3: “Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилт:

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй, найдвартай хангахад чиглэсэн үр ашигтай үндэсний төмөр замын дотоодын нэгдсэн

сүлжээг өргөжүүлж, улмаар улс орны дамжин өнгөрүүлэх чадавхийг дээшлүүлэн, салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг экспортлох болон боловсруулан экспортолж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлэх, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд нийт 7 чиглэлийг хэрэгжүүлэхээр тусгасан.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан үйл ажиллагааг чиглэлээр нь авч үзвэл:

№	Арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	1.2. Бодлогын хүрээнд шийдвэрлэх	7
2.	2.1. Төмөр замын суурь бүтцийг өргөжүүлэх, шинээр барих чиглэл болон уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулж экспортод гаргах асуудлуудыг харилцан уялдаатай шийдвэрлэх	11
3.	3.1. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ өргөжүүлэх	33
4.	4.1.1. Төмөр замын царигийн сонголт нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжид нийцэх	6
5.	5.1.Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх	3
6.	6.1.1. Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлого, зохицуулалтаар хангах	7
7.	7.1.Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн	6
НИЙТ		73

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхээр нийт 73 арга хэмжээнээс 2020 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй 44, 90%-ийн биелэлттэй 4, 70%-ийн биелэлттэй 5, 50%-ийн биелэлттэй 2, 30%-ийн биелэлттэй 17, 0 үнэлгээтэй буюу хэрэгжээгүй 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **78.3** хувьтай байна.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг ангилан үнэлбэл:

№	Бүлгүүд	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	Нэг. Нийтлэг үндэслэл	7	5	-	2	-	-	-	91.4
2	Хоёр. Төмөр замын тээвэр, ашигт малтмалын орд	11	4	1	-	1	5	-	62.7
3	Гурав. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ	33	20	3	1	-	8	1	78.2
4	Дөрөв.Төмөр замын шугамын цариг	6	3	-	1	-	2	-	71.7
5	Тав. Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн зохицуулалт	3	3	-	-	-	-	-	100.0
6	Зургаа. Бодлогын хэрэгжилт,	7	5	-	-	1	1	-	82.5

	санхүүжилтийн эх үүсвэр								
7	Долоо. Бодлогын хэрэгжилтийн үр дүн	6	4	-	1	-	1	-	83.3
Нийт		73	44	4	5	2	17	1	78.3

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн байдлыг бүлэг тус бүрээр нь үнэлбэл:

Бүлгүүд	Үүнээс хэрэгжилтийн хувиар						Дундаж хувь
	100	90	70	50	30	0	
Нэг. Нийтлэг үндэслэл	1.2.1.1. 1.2.1.2. 1.2.1.4. 1.2.1.5. 1.2.1.7.		1.2.1.3. 1.2.1.6.				91.4
Хоёр. Төмөр замын тээвэр, ашигт малтмалын орд	2.2.1. 2.2.2. 2.2.3. 2.2.4.	2.4.3		2.4.4.	2.1. 2.3.1. 2.3.2. 2.4.1. 2.4.2		62.7
Гурав. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ	3.1.1. 3.1.2. 3.1.3. 3.1.4. 3.1.5. 3.1.6. 3.2.1. 3.2.3.1. 3.2.3.4. 3.2.4.1. 3.2.4.2. 3.2.4.4. 3.2.4.5. 3.2.5.3. 3.2.5.4. 3.2.6.3. 3.3.1.1. 3.3.1.2. 3.3.2.1. 3.3.2.2.	3.2.3.2 . 3.2.5.1 . 3.2.5.2 .	3.2.2.		3.2.3.3 . 3.2.4.3 . 3.2.4.6 . 3.2.6.1 . 3.2.6.2 . 3.3.2.3 . 3.3.2.4 . 3.3.2.5 .	3.2.6.4.	78.2
Дөрөв. Төмөр замын шугамын цариг	4.1.1. 4.1.2. 4.2.3.		4.2.1.		4.2.2. 4.2.4.		71.7
Тав. Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн зохицуулалт	5.1. 5.2. 5.3.						100.0

Зургаа. Бодлогын хэрэгжилт, санхүүжилтийн эх үүсвэр	6.2.1.1. 6.2.1.2. 6.2.1.3. 6.2.1.4 6.3.1.			6.1.1.	6.4.1.		82.5
Долоо. Бодлогын хэрэгжилтийн үр дүн	7.1.1. 7.1.4. 7.1.5. 7.1.6.		7.1.3.		7.1.2.		83.3
Нийт	44	4	5	2	17	1	78.3

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувиар үнэлэгдсэн 2 арга хэмжээ, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувиар үнэлэгдсэн 17 арга хэмжээ, хэрэгжилт тасарсан буюу хэрэгжүүлээгүй 1 арга хэмжээ байна.

2.7. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт:

Зам, тээврийн салбарт 2020 оны байдлаар Засгийн газрын 2007.07.10-ны өдрийн 175 дугаар тогтоолоор баталсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”, Засгийн Газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 283 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”, 2019 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/”, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 171 дугаар тогтоолоор батлагдсан “Тээврийн ухаалаг ситемийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн явцыг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримталсан.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд дараах байдлаар үнэлэгдсэн байна.

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Батлагдсан хугацаа	Тогтоолын дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	2020 оны үнэлгээ	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
1	Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр	2007.07.10	ЗГ №175	хугацаагүй	94%	байхгүй
2	Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр	2010.11.10	ЗГ №289	хугацаагүй	85,3%	байхгүй
3	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр	2018.05.02	ЗГ №120	2018-2022	34,5%	28,7%
4	Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр	2019.07.03	ЗГ №283	2019-2023	65,6%	48,1%
5	“Замын хөдөлгөөний	2019.04.23	ЗГ №163	2019-2023	51%	0,3%

	аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”					
6	“Тээврийн ухаалаг ситемийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”	2020.05.13	ЗГ №171	2020-2024	34.5%	байхгүй

“Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-т Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т Засгийн газрын 2010 оны 164 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 128, 2010 оны 164, 2015 оны 128, 2019 оны 13 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 170 дугаар тушаал, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 309 дүгээр тушаалаар баталсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Ерөнхий сайдаар ахлуулан зохион байгуулж, “Төлөвлөгөө, журам, зөвлөмж, загвар батлах тухай” Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2021.03.31-ний өдрийн 01/1301 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.7.1. “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”

“Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр” нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хөтөлбөрийн 230 заалтын хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 187, 90%-ийн хэрэгжилттэй 5, 70%-ийн хэрэгжилттэй 14, 50%-ийн 5, 30%-ийн хэрэгжилттэй 7, хэрэгжээгүй 12 заалттай, хэрэгжилтийн дундаж **85,3** хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

Дараах арга хэмжээнүүдийг “хэрэгжээгүй”, “хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэлээ. Үүнд:

Хэрэгжээгүй:

1. 3.2.2. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Doc 9303-ын 1 дүгээр хэсэгт заасны дагуу машинаар уншигдах цахим паспорт олгох; (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

2. 3.2.3. гадаад улсад зорчих баримт бичгийг шинэчлэхдээ дараах стандартыг баримтална: паспорт, виз болон бусад гадаад улсад зорчих баримт бичигт биометрикийн нэг буюу түүнээс дээш мэдээллийг цахим аргаар уншигдах байдлаар хадгалах; цахим аргаар хадгалагдах мэдээлэл нь баримт бичгийн хуудсан дахь тоон гэрэл зураг, машинаар уншигдах мэдээлэлтэй адил байх; нэмэлт биометрик мэдээллийг машинаар уншигдах паспортад оруулах тохиолдолд ISO/IEC 14443-ийн шаардлага хангасан микросхем ашиглах ба Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын стандартад нийцсэн программчлалтай байх; машинаар уншигдах гадаад улсад зорчих баримт бичигт хугацааны сунгалт хийгдэхгүй ба уншигдах хэсэгт өөрчлөлт, засвар оруулах боломжгүй болгох. 0%

3. 3.2.6. хулгайлагдсан, гээгдсэн болон цуцлагдсан аяллын баримт бичгийн талаарх мэдээллийг “Интерпол”-д нэн даруй мэдэгдэж, “Хулгайлагдсан, гээсэн аяллын баримт бичгийн мэдээллийн сан /SLTD/”-д бүртгүүлэх; (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмсэн)
4. 3.3.17. “Зорчигчийн нэр, бүртгэлийн өгөгдөл (PNR)”-ийг шилжүүлэхэд НҮБ-ын Удирдлага, худалдаа, тээврийн цахим өгөгдлийн солилцооны дүрэм (EDIFACT)-д суурилсан “Агаарын тээвэрлэгч-Засгийн газар /PNRGOV/” гэсэн өгөгдөл шилжүүлгийн үндсэн аргыг ашиглах; (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмсэн)
5. 3.4.16. “Аяллын цахим систем”-ийг хэрэгжүүлэх хуваарийг бусад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага, аялал жуулчлалын байгууллага, агаарын тээвэрлэгч болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэн, хамтран ажиллах бөгөөд дараахь арга хэмжээг авах: (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмсэн) 3.4.16.1. “Аяллын цахим систем”-ийг нэвтрүүлэхдээ “Аяллын өмнөх баталгаажуулалтын систем”-ийг “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн интерактив систем (iAPI)”-тэй нэгтгэх
6. 3.4.16.2. зорчигч нислэгийн захиалга өгөх үед түүнд “Аяллын цахим систем”-ийн шаардлагын талаар мэдээлэл өгөх;
7. 3.4.16.3. Монгол Улсад зорчих хүсэлтийг хүлээж авах цахим бүртгэлийн найдвартай платформуор хангаж, уг систем нь албан бус гуравдагч борлуулагч этгээд нэмэлт төлбөр авахыг хязгаарлах зорилготой албан ёсны систем болохыг баталгаажуулах;
8. 3.4.16.4. зорчих хүсэлтийн маягыг бөглөх үед алдаа гаргахаас сэргийлэх нэмэлт хэрэгсэл бий болгох, хилээр нэвтрүүлэхийг үл зөвшөөрөх зорчигчийн хүсэлтийг хүлээн авахгүй байх боломж бүрдүүлэх;
9. 3.10.3 зайлшгүй шаардлагаар агаарын хөлөг олон улсын хилийн боомтгүй нисэх буудалд буулт үйлдэх тохиолдолд буулт үйлдэх боломжоор хангах, зогсоол бэлтгэх, агаарын хөлгийн баг, зорчигчдыг түр хугацаагаар буух талбайгаар хангаж, хяналтын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.
10. 3.11.9. зорчигчийн урьдчилсан мэдээллийн өгөгдөл (API, iAPI, PNR) солилцох “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, нэг нислэгийн зорчигчийн урьдчилсан мэдээллийг дахин шаардахгүй байх, системийн гэмтэл, доголдлоос шалтгаалан мэдээллийг дамжуулаагүй эсхүл дутуу, гэмтсэн мэдээлэл дамжуулсан тохиолдолд агаарын тээвэрлэгчид торгууль ногдуулахгүй байх; (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмсэн)
11. 4.6.5 агаарын тээврийг хялбаршуулахтай холбогдсон үйл ажиллагаа, арга хэмжээ нь Монгол Улсын аялал жуулчлал, олон улсын худалдааны хөгжилд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, үнэлгээ өгөх;
12. 5.19 Хилийн хяналтын байгууллага нь ердийн нөхцөлд зорчигчийн тээшинд үзлэг, шалгалт хийхдээ өөрийг нь заавал байлцуулахыг шаардахгүй.

Хэрэгжилт хангалтгүй:

1. 3.1.3 агаарын тээврийг хялбаршуулах олон улсын стандарт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа хийх, дүгнэлт гаргах;
2. 3.1.11. Агаарын тээврийн хялбаршуулах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Монгол Улстай агаарын харилцаа бүхий улс орнуудтай хамтран ажиллах;
3. 3.2.1. гадаад улсад зорчих баримт бичгийг зохиох, хэвлэх, тараах болон нэмэлт өөрчлөлт хийхдээ олон улсын стандартад нийцүүлэх;
4. 3.3.22. хөгжлийн бэрхшээлтэй зорчигч нь түүнд туслах хүн хэрэгтэй эсэхийг өөрөө тогтоох бөгөөд гагцхүү уг зорчигчийн биеийн байдал өөрт нь болон бусад зорчигчийн аюулгүй, ая тухтай байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл туслах хүнтэй зорчихыг шаардаж болох, энэ тохиолдолд туслах хүнд үнийн хөнгөлөлт үзүүлэх; (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 14 дүгээр тогтоолоор нэмсэн)
5. 3.5.16. Хилээр нэвтэрч буй зорчигч бүрийн аяллын баримт бичгийг Интерполын “Хулгайлагдсан, гээсэн аяллын баримт бичгийн мэдээллийн сан”-гаас боломжийн түвшинд шүүж, тулгах.

6. 3.6.2 шаардлагатай тохиолдолд хилийн хяналтын байгууллага, нисэх буудал, агаарын тээвэрлэгчийн ажилтан, зорчигчдод урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлыг зохион байгуулах, холбогдох гэрчилгээ олгох;
7. 3.7.14 барааны гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулахын тулд ачааны мэдээллийг урьдчилан авах, ачаа тээвэрлэгчдийн систем хоорондын харилцан ажиллагааг хангах, барааны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцооны цахим системийг боловсронгуй болгох;
8. 3.7.15 эрх бүхий төрийн байгууллагаас шаардсан ачаа болон агаарын хөлөг ирэх, буцахтай холбоотой мэдээллийг нэг цонхны үйлчилгээний системд байршуулах;
9. 4.7 Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зохион байгуулна.
10. 5.5 Хилийн мэргэжлийн хяналтын байгууллага нь агаарын хөлөгт ариутгал халдваргүйтгэл, шавьж хорхой, мэрэгч амьтаны устгал хийсэн бол ерөнхий мэдүүлэгт тэмдэглэл хийж, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн Хавсралт-9 (Үйл ажиллагааг хялбарчлах)–д заасан маягтын дагуу гэрчилгээ олгоно.
11. 5.36 Гадаадын иргэн, харъяатын асуудал хариуцсан байгууллага нь гадаад иргэний эх орондоо буцах зорилгоор аяллын баримт бичиг авах хүсэлтийг 30 хоногийн дотор хянан үзэж, тодорхой хугацаа заасан аяллын баримт бичиг олгох эсхүл тухайн улсын иргэн биш гэсэн нотолгоо гаргаж өгөх байдлаар асуудлыг шийдвэрлэнэ.
12. 7.1. Энэхүү хөтөлбөрийн дагуу үүрэг хүлээсэн байгууллага нь хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

2.7.2. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”

“Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2007 оны 07 сарын 10-ны өдрийн 175 дугаар тогтоолоор баталсан бөгөөд Засгийн газрын 2010 оны 164 дүгээр тогтоол, 2015 оны 128 дугаар тогтоол, 2019 оны 13 дугаар тогтоол, 2020 оны 5 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хөтөлбөрийн 129 заалтын хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 103, 90%-ийн хэрэгжилттэй 11, 70%-ийн хэрэгжилтэй 5, 50%-ийн хэрэгжилттэй 4 заалт, 0%-ийн хэрэгжилттэй 3 заалт, үнэлэх боломжгүй 3 заалттай, хэрэгжилтийн дундаж **94** хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн байна. Дараах арга хэмжээнүүдийг “үнэлэх боломжгүй”, “хэрэгжээгүй”, “хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэлээ. Үүнд:

Үнэлэх боломжгүй:

1. 4.2.10 хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, үйл ажиллагаанд үнэлэлт өгч, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх.
2. 5.9. Ерөнхий газар нь аль нэг улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул заналхийлж байгаа талаар олж авсан мэдээллийг Зөвлөлд болон тухайн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
3. 5.16. Нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бусад улсын эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын хяналтын арга хэмжээтэй давхардуулахаас сэргийлж, аюулгүй байдлын тогтвортой тогтолцоог бүрдүүлэхийн тулд бусад улсын ижил үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах боломжийг эрэлхийлнэ. Аялал эхэлж буй улсад хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын хяналтын арга хэмжээний үр дүн нь ижил түвшинд байгааг баталгаажуулсны үндсэн дээр гэрээ байгуулна. /Засгийн газрын 2019 оны 13 дугаар тогтоолоор нэмсэн/

Хэрэгжээгүй:

1. 5.12. Тагнуулын байгууллага нь энэ хөтөлбөр болон үндэсний бусад баримт бичигт заасан байгууллагын ашигладаг иргэний нисэхийн чухал мэдээлэл, харилцаа, холбооны систем,

өгөгдлүүдийг тодорхойлсон байх бөгөөд тэдгээрийг эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээний дагуу хууль бус халдлагаас хамгаалах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

2. 5.17. Тагнуулын байгууллага нь нисэх буудлын хориотой бүсэд нэвтрүүлэх худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн шат, дамжлага бүрийн аюулгүй байдал, харилцаа, холбооны систем, өгөгдлүүдийн аюулгүй байдлын төлөвлөлт, сүлжээний тусгаарлалт, хамгаалалт, алсын тандалтын хязгаарлалтын арга хэмжээ авснаа баталгаажуулна.

3. 5.20. Ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагууд өөрсдийн нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг үр дүнтэй хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хоорондоо тухай бүр солилцох зохицуулалт бүхий журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт хангалтгүй:

1. 5.5. Зөвлөл нь жилд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааны шийдвэр, протоколыг гишүүн бүрт хүргүүлнэ. Зөвлөлийн хуралд техникийн шинжээч, мэргэжилтнүүдийг урьж оролцуулж болно.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны ээлжит хурлуудыг 2020 оны 3 дугаар сарын 17, 7 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан. 50%

2. 15.6 Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, агаарын хөдөлгөөний үйлчилгээний байгууллага ачаа тээвэр зуучийн болон иргэний нисэхийн аюулгүй байдлын байгууллагын үйл ажиллагаанд хийх аюулгүй байдлын сорилтод ашиглах зүйлийг баталгаажуулж, дотоод сорилтыг улирал тутам ил аргаар хийнэ.

3. 15.7. Аюулгүй байдлын сорилтыг Ерөнхий газрын зөвшөөрөлтэйгээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийнэ.

4. 15.11. ИНЕГ нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, агаарын хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, ачаа тээвэр зуучийн болон иргэний нисэхийн аюулгүй байдлын байгууллагын үйл ажиллагаанд хийх аюулгүй байдлын сорилтод ашиглах эд зүйл хэрэгслийг баталгаажуулж, дотоод сорилтыг улирал тутам хийнэ.

2.7.3. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” нь Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд хөтөлбөрийг 2018-2022 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 170 дугаар тушаалаар баталсан.

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан 51 заалтын хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 5, 70%-ийн хэрэгжилттэй 8, 50%-ийн хэрэгжилттэй 13, 30%-ийн хэрэгжилттэй 19, 0%-ийн хэрэгжилттэй 6 заалттай, хэрэгжилтийн дундаж **34,5** хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн.

Хөтөлбөрт 2018-2022 онд нийт 7 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Зорилт 1. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх – 55%
- Зорилт 2. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх – 48,9%
- Зорилт 3. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах – 50%
- Зорилт 4. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын боловсон хүчин бэлтгэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх - 25%

- Зорилт 5. Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээний төв байгуулах болон засвар үйлчилгээний сүлжээг бүрдүүлэх – 18%
- Зорилт 6. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээг бүрдүүлэх – 43,3%
- Зорилт 7. Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх - 34%

Дараах арга хэмжээнүүдийг “хэрэгжээгүй”, “хэрэгжилт удаашралтай” гэж дүгнэлээ.
Үүнд:

Хэрэгжээгүй:

- 1/ 2.2.3. Орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар ангарын барилга байгууламж, шатахуун хангамжийн төв барих, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх. /Шатахуун хангамжийн 30 төв байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах/
- 2/ 4.1.2. Олон улсын стандарт шаардлага хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах Сургалтын төв байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах /Сургалтын төв, нисэх клуб 25-ыг байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах/
- 3/ 4.2.1. Монгол Улсад нисэгч, инженер техникийн ажилтныг бэлтгэх зах зээлийн судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг тогтоож, сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх / Судалгаа хийх, 100-аас доошгүй нисэгч бэлтгэх/
- 4/ 5.2.1. Бага оврын агаарын хөлгийг угсрах, үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх ажлыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. /60-аас доошгүй засвар, үйлчилгээний төв байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах/
- 5/ 5.3.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн засвар үйлчилгээний төв байгуулахыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх.
- 6/ 6.2.2. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв, агуулахын оновчтой сүлжээг бий болгох /30-аас доошгүй байршилд шатахуун хангамжийн төв байгуулах/

Хэрэгжилт хангалтгүй:

- 1.1.1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дараах зохицуулалтыг тусгах, Үүнд: Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох талаар;
 - Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага;
 - Ерөнхий зориулалтын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих Нисэхийн хөгжлийн сан байгуулах. 50%
- 1.2.2 Бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах /Хяналтыг хялбаршуулах, боловсронгуй болгох/ 50%
- 1.2.3. Ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулж, нислэгийн захиалга, төлөвлөлтийг хялбаршуулах /Мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулах/ 50%
- 1.2.4. “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам”-д шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг сайжруулах /Зохицуулалтыг боловсронгуй болгох/ 50%
- 1.3.2. Нислэгийн үйл ажиллагаанд оролцогчд талуудын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хангалтын шаардлагыг тогтоох, үйл ажиллагааны журам, зааварт тусгах /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 50%
- 1.4.1.Орон нутгийн засаг захиргаа, хөдөө аж ахуй, онцгой байдал, эрүүл мэнд, байгаль хамгаалах зэрэг чиглэлээр хамтран ажиллах хүрээг тодорхойлох /Хамтран ашиглах зохицуулалт бүрдэж, хэрэгжих/ 50%
- 1.4.2. Аялал жуулчлалын чиглэлийг нисэх буудал, ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх /Хамтран ашиглах зохицуулалт бүрдэж, хэрэгжих/30%
- 1.4.3. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, онцгой байдлын үед ашиглах хөөрч буух зурвас, вертодром байгуулах байршлыг хамтран тогтоож, хэрэгжүүлэх /10-аас доошгүй байршил тогтоох, байгуулах/ 50%

- 1.5.1. Агаарын хөлгийн бүртгэлтэй уялдуулж ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох /Агаарын хөлөг барьцаалан зээл авах тогтолцоо бүрдэж хэрэгжих/. 30%
- 1.5.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийг сургалтын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс түрээсээр авч ашиглах зохицуулалт бүрдүүлэх /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%
- 1.7.1. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах газрын хэмжээ, байршлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран тогтоож, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах /Хөөрч, буух 116 зурвас, шатахуун хангамжийн 30 төв байгуулах байршлыг тогтоох, баталгаажуулах/ 50%
- 1.7.2. Ерөнхий зориулалтын нисэхт ашиглах газрын суурь үнэлгээг тогтоох, газрын төлбөрийг бууруулах, чөлөөлөх талаар холбогдох хууль тогтоомжид тусгах /Газрын төлбөрийн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%
- 1.7.3. Хөөрч буух зурвас, вертодром, шатахуун хангамж, ангар барих зэрэг газрын зориулалт, төлөвлөлтийг тодорхойлох, байршлыг тогтоох /Газрын төлөвлөлт тодорхой болох/ 30%
- 2.1.1. Барилга байгууламжийн зохих хэсгийг агаарын хөлгийн засвар үйлчилгээ, сургалтын чиглэлээр ашиглах ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон зохион байгуулах /Ерөнхий зориулалтын нисэхийн төв байгуулах/ 30%
- 2.2.2. Сэргээн сайжруулсан нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайн засвар арчлалт, ашиглалтыг орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх тогтолцоо бүрдүүлэх /Хөөрч, буух 116 зурвас байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах/ 30%
- 2.3.2. Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан батлуулах /Дэд хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх/ 50%
- 2.5.1. Орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хөөрч, буух зурвас, вертодром барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх. /Хувийн вертодром байгуулах, ашиглах боломж бүрдүүлэх/ 30%
- 3.1.1. Иргэний нисэхийн багц дүрэм, холбогдох журамд тусган батлуулах. /Холбогдох зохицуулалтыг тусгах, Хэрэгжүүлэх/ 50%
- 3.2.1. Иргэний нисэхийн багц дүрэмд нийцүүлэн агаарын зайн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашиглалтыг хялбаршуулах /Доод агаарын зайн ашиглалтыг сайжруулах/ 50%
- 3.2.2. Олон улсын болон орон нутгийн нисэх буудалд ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр шөнийн, хэрэглэлийн нислэгийн дүрмээр нислэг үйлдэх схем боловсруулах /Нислэг үйлдэх схем батлуулах, хэрэгжүүлэх/ 30%
- 3.3.1. Ил харааны нислэгийн газрын зурагт газарзүйн байршил, агаарын зайн ангиллыг тэмдэглэж батлуулах 50%
- 4.1.1. Хувийн нисэгч бэлтгэх анхан шатны сургалтын төвүүд байгуулах тогтолцоо бүрдүүлэх, хэрэгжүүлэх /Сургалтын төв, нисэх клуб 25-ыг байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах/ 30%
- 5.1.1. Бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэх чиглэлээр гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалт хийх таатай орчинг бий болгох. /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%
- 5.1.2. Бага оврын агаарын хөлөг түрээсээр болон худалдан авахад агаарын хөлгийг барьцаалан урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох дотоодын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх / Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%
- 5.4.1. Агаарын хөлгийн сэлбэг, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний сүлжээ бий болгох эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%
- 6.2.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулах, нийлүүлэх эх үүсвэр, хилийн боомтыг тогтоох судалгаа хийх /Судалгаа хийх, хэрэгжүүлэх/ 30%
- 7.1.1. Хувийн хэрэгцээнд ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоох судалгаа хийх. /Стандарт батлах, хэрэгжүүлэх/ 30%
- 7.1.2. Хувийн хэрэгцээнд бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэг ашиглах, эйр такси болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%

7.1.3. Агаарын хөлөг худалдан авах, түрээслэхэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар судалгаа хийх, шийдвэрлэх./Судалгаа хийх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох/ 30%

7.2.1. Холбогдох зохицуулалтыг “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам”-д тусгах, хэрэгжүүлэх /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%

7.2.2. Агаарын хөлгийн тракинг систем, зөөврийн ELT зэрэг төхөөрөмжийг өргөн ашиглах, импортлох, энэ чиглэлээр дотоодын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх /Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих/ 30%

2.7.4. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”

“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” нь Засгийн Газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 283 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд хөтөлбөрийг 2019-2023 онд 2 үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 309 дүгээр тушаалаар баталсан.

“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан 25 заалтын хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 8, 90%-ийн хэрэгжилттэй буюу 1, 70%-ийн хэрэгжилттэй 6, 50%-ийн хэрэгжилттэй 3, 30%-ийн хэрэгжилттэй 6, 0%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээтэй, хэрэгжилтийн дундаж **65,6** хувьтай “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсаргав.

Хөтөлбөрт 2018-2022 онд нийт 3 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Зорилт 1. Орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох-44.3%
- Зорилт 2. Орон нутгийн нислэгийг үе шаттайгаар сэргээн тогтворжуулах-81,7%
- Зорилт 3. Зорилтот бүлгийн иргэд орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих тогтолцоо бүрдүүлэх-43.3%

Дараах 10 арга хэмжээнүүдийг “хэрэгжээгүй” болон “хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэлээ. Үүнд:

1. 3.3.1. Зорилтот бүлгийн иргэдэд хөнгөлөлттэй тийзийг зохих бичиг баримтыг үндэслэн олгох тогтолцоо бүрдүүлэх

Биелэлт: “Зорилтот бүлгийн иргэд хөнгөлөлттэй үнээр орон нутгийн нислэгээр зорчих журам”-ын 2.3 дахь заалтад зорилтот бүлгийн иргэдийг 80 хүртэлх хувиар хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан боловч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/1296 тоот албан бичгийн дагуу журмыг хүчингүй болгосон. 0%

2. 1.2.1. Иргэний нисэхийн салбарт төрөөс дунд болон урт хугацаанд баримтлах бодлогын баримт бичигт агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үе шат бүхий цогц арга хэмжээнүүдийг тодорхойлох;

Биелэлт: “Дэд бүтцийн зорилтот хөтөлбөр”-т тусгахаар ажиллаж байна. 30%

3. 1.3.2. Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний талаар гадаад орнуудын туршлагыг судлан, нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Биелэлт: Судалгаа хийж байна. 30%

4. 2.3.3. Улаанбаатар-Баруун-Урт чиглэлд нөхөн олговор олгох нөхцөлтэйгээр нислэг гүйцэтгүүлэх;

Биелэлт: Улаанбаатар-Баруун-Урт чиглэлд нөхөн олговортой нислэг гүйцэтгүүлэх үнэлгээний хороог ИНЕГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/221 дүгээр тушаалаар байгуулан, Улаанбаатар – Баруун-Урт - Улаанбаатар чиглэлд нөхөн олговортой нислэгийн тендерийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 9 дүгээр сарын 23-ны

өдөр зарлан 10 дугаар сарын 08-ны өдөр нээсэн хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгч шалгараагүй. 30%

5. 2.3.4. Улаанбаатар-Тосонцэнгэл чиглэлд нөхөн олговор олгох нөхцөлтэйгээр нислэг гүйцэтгүүлэх;

Биелэлт: Улаанбаатар-Тосонцэнгэл чиглэлд нөхөн олговортой нислэг гүйцэтгүүлэх үнэлгээний хороог ИНЕГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/221 дүгээр тушаалаар байгуулан, тендерийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зарлан 10 дугаар сарын 08-ны өдөр нээсэн хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгч шалгараагүй. 30%

6. 2.3.5. Ховд–Ховд аймгийн Булган сум чиглэлд нөхөн олговор олгох нөхцөлтэйгээр нислэг гүйцэтгүүлэх;

Биелэлт: “Геосан” ХХК-ийн 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 02/250 тоот албан бичгээр, “Тэнгэрийн улаач шинэ” ХХК-ийн 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн ТУ-02/178 тоот албан бичгүүдээр тухайн агаарын тээвэрлэгчид хөдөө орон нутагт, Ховд аймгийн Булган Сумд байрлаж нислэг гүйцэтгэх боломжгүй талаар мэдэгдсэн. 30%

7. 3.2.1. “Зорилтот бүлгийн иргэд хөнгөлөлттэй үнээр орон нутгийн нислэгээр зорчих журам” боловсруулан батлуулах

Биелэлт: Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн А/79 тоот тушаалаар “Зорилтот бүлгийн иргэд хөнгөлөлттэй үнээр орон нутгийн нислэгээр зорчих журам”-ыг баталсан хэдий ч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/1296 тоот албан бичгийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/458 дугаар тушаалаар хүчингүй болгосон. 30%

8. 1.1.1.“Иргэний нисэхийн тухай” хуулиар агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд оролцогчдын эрх үүрэг, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлох;

Биелэлт: “Иргэний нисэхийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 7.1.6-д тусгасан. Мөн “Нөхөн олговортой нислэг зохицуулах дүрэм”-ийн төсөл боловсруулсан бөгөөд тус төсөлд агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд оролцогчдын эрх үүрэг, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлсон. 50%

9. 1.3.1. Орон нутгийн нисэх буудлуудын нисэхийн болон нийтлэг үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх судалгаа

Биелэлт: “Нисэхийн бус нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/3975 тоот албан бичгээр ЗТХЯ-д хүргүүлсэн. 50%

10. 2.3.1. Эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн шаардлагатай чиглэлд нөхөн олговор олгох нөхцөлтэйгээр нислэг гүйцэтгүүлэх

Биелэлт: Судалгаа хийж сэргээн тогтворжуулах шаардлагатай 8 чиглэлд нөхөн олговор олгох 2,175,100,000 төгрөгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны урсгал зардлын төсөвт тусгуулсан. 641,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй. 50%

2.7.5. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг, хоёрдугаар хавсралтаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг, 2019 оны 163 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/-ийг тус тус баталсан.

“Төлөвлөгөө, журам, зөвлөмж, загвар батлах тухай” Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг, хоёрдугаар хавсралтаар замын

хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журмыг, гуравдугаар хавсралтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмжийг, дөрөвдүгээр хавсралтаар Үндэсний зөвлөлийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг тус тус баталсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд стратегийн 4 зорилтын хүрээнд 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг чиглэл тус бүрээр авч үзвэл:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21
2.	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	26
3.	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	32
4.	“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	14
НИЙТ		93

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 93 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2020 оны жилийн эцсийн байдлаар 100% хэрэгжсэн 10, 90%-ийн хэрэгжилттэй 3, 70%- ийн хэрэгжилттэй 17, 50%- ийн хэрэгжилттэй 26, 30%- ийн хэрэгжилттэй 33, 0% буюу тасарсан 4 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт **51.0** хувьтай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилан авч үзвэл:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21	5	3	3	6	4	-	66.7
2	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	26	5	-	9	5	6	1	60.0
3	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	32	-	-	4	11	16	1	40.9

4	“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	14	-	-	1	4	7	2	34.3
Нийт		93	10	3	17	26	33	4	51.0

2.7.6 “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт

“Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 8 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар бүлэг, Зам, тээврийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалыг тус тус баримтлан “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2020-2024/, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг үндсэн мэдээлэл болгон ашигласан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоолоор “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2020-2024/-ийг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн А/182 дугаар тушаалаар “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд стратегийн 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг чиглэл тус бүрээр авч үзвэл:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх зорилт	7
2.	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх зорилт	11
3.	Цахим төлбөрийн системийг хөгжүүлэх зорилт	7
4.	Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилт	10
5.	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	14
Нийт		49

Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2020 оны жилийн эцсийн байдлаар 90%-тай 2, 70%-тай 5, 50%-тай 4, 30%-тай 9, 0%-тай 9, хугацаа болоогүй 20 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт **34.5** хувьтай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилан авч үзвэл:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар							Хувь
			100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
1	Замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх зорилт	7	-	-	-	-	2	1	4	20.0
2	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх зорилт	11	-	1	2	-	-	4	4	32.9
3	Цахим төлбөрийн системийг хөгжүүлэх зорилт	7	-	1	2	-	1	1	2	52.0
4	Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилт	10	-	-	-	1	3	1	5	28.0
5	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	14	-	-	1	3	3	2	5	34.4
Нийт		49		2	5	4	9	9	20	34.5

Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоолын 6.2-т хөтөлбөрийн үр дүнг үнэлэх 9 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба үүнээс 2019 оны байдлаар 2 шалгуур үзүүлэлт суурь түвшинтэй, 7 шалгуур үзүүлэлт шинээр хийгдэх ажил байна. Эдгээр 9 шалгуур үзүүлэлтийн 2024 оны зорилтот түвшинг тодорхойлж өгсөн.

Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулахдаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хүрэх түвшинг тодорхойлсон ч арга хэмжээний хэрэгжиж эхлэх үеийн суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, зорилтот түвшин буюу хүрэх түвшинг он оноор зааглаж өгөөгүй дутагдал байна.

2.8. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 11 төслийг хамруулан 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнээс дараах 4 төсөл 2019 онд хэрэгжиж дууссан боловч 2020 онд сүүлийн гүйцэтгэл, барьцааны үлдэгдэл санхүүжилт хийгдсэн тул тайланд оруулан үнэлгээ хийлээ. Үүнд:

1. “Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32,226 км хурдны авто зам”
2. “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам”
3. “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129,4 км хатуу хучилттай авто зам”
4. “Бүс нутгийн логикийн төвийг хөгжүүлэх төсөл”

Нийт 11 арга хэмжээнээс 4 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ба хэрэгжилт дунджаар **72.4** хувьтай байна.

№	Төслийн нэр	Арга хэмжээний нэр	2020 оны үнэлгээ	Төслийн хэрэгжилт
1	“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2”	Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН4 чиглэлийн авто замын трассын дагуу баригдах 189.7 км хатуу хучилттай авто зам (Багц CW1-1, Багц CW1-2, Багц CW1-3, CW1-4 хэсгүүд)	70%	72,8%
2	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хүрээнд	“Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32,226 км хурдны авто зам”	-	100%
3		“Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам”	-	100%
4		“Баянхонгор-Байдрагын гүүр чиглэлийн 129,4 км хатуу хучилттай авто зам”	-	100%
5		“Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам”	70%	76,5%
6	Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил	30%	35.7%
		Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажил		
		Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар		
7	Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн төсөл”	Улаанбаатар-Дархан чиглэлийн 202,42 км авто замын өргөтгөлийн төсөл	70%	-
8	“Монгол улс: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцагч байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх нь” техникийн туслалцаа (TA-9579 MON)		100%	100%
9	Бүс нутгийн логикийн төвийг хөгжүүлэх төсөл		-	100%
10	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл		96,8%	99,2%
11	Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”	Багц-1 Барилга байгууламжийн ажил	70%	27,2%
		Багц-2 Аэродромын барилга угсралтын ажил		
Дундаж үнэлгээ			72.4%	81,1%

Зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2021.03.21-ний өдрийн 01/791 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

2.9. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 9 хуулийн 41 заалт, Улсын Их Хурлын 5 тогтоолын 8 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 2 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 10 тогтоолын 21 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 5 зөвлөмжийн 5 заалт, Засгийн газрын 100 тогтоолын 138 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт, Засгийн газрын хуралдааны 70 тэмдэглэлийн 106 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 15 заалт буюу нийт 207 шийдвэрийн 340 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгавраас бүрэн хэрэгжсэн 286, хэрэгжих шатанд байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 27, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 2, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 25 заалт байгаа бөгөөд хэрэгжилт **96.9** хувьтай байна.

Хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад үүрэг болгосон шийдвэрүүдийн заалт нэг бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн удирдлагад танилцуулан ажиллаж байна.

№	Шийдвэрийн төрөл	Шийдвэрийн		Хэрэгжилтийн үнэлгээ			
		тоо	заалт	Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалтгүй 30%	Хугацаа болоогүй
1	Монгол Улсын хууль	9	41	30	3	-	8
2	Улсын Их Хурлын тогтоол	5	8	7	1	-	-
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	10	21	14	4	2	1
4	Ерөнхийлөгчийн зарлиг	2	2	1	1		
5	ҮАБЗ-ийн зөвлөмж	5	5	4	1	-	-
6	Ерөнхий сайдын захирамж	4	4	4	-	-	-
7	Засгийн газрын тогтоол	100	138	117	7	-	14
8	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	70	106	95	9	-	2
9	Засгийн газрын албан даалгавар	2	15	14	1	-	-
Нийт		207	340	286	27	2	25

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2021.01.15-ны өдрийн 01/187 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.10. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2013-2020 оны нийт 247 тушаалын 495 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь үзүүлвэл:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Биелэлт хувь
			100	70	30	биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй	
1	Дэд сайд	11	8	-	1	-	2	92.22
2	ТНБД	38	31	6	1	-	-	93.42
3	БТГ	47	38	5	1	-	2	95.00
4	ТЗУГ	25	21	3	-	-	1	96.25
5	ХШУДАГ	95	72	14	2	-	7	93.64
6	АЗБХЗГ	61	46	9	-	-	6	95.09
7	АТБХЗГ	49	37	8	2	-	2	91.91
8	ТЗДТБХЗГ	48	43	3	-	-	2	98.04
9	АгТБХЗГ	32	27	3	1	-	1	94.84
10	ИНЕГ	131	87	17	1	-	26	94.48
11	ЗТХТ	66	58	4	-	-	4	98.06
12	АТҮТ	113	90	13	3	-	7	94.34
13	ГТХЗНТ	48	44	2	-	-	2	98.70
14	МИАТ	57	51	1	-	-	5	99.42
15	УБТЗ	100	92	2	1	-	5	98.63
16	МТЗ	71	66	2	-	-	3	99.12
17	Далайн захиргаа	53	45	2	-	-	6	98.72
18	НТОЗШША	11	6	-	-	-	5	100.0
19	ХХНОБ	18	13	1	-	-	4	97.86
НИЙТ		1074	875	95	13	-	90	93.03
		495	376	55	11	-	53	94.52

Сайдын тушаалын хэрэгжилтийн байдалд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 376, 70%-ийн хэрэгжилттэй 55, 30%-ийн хэрэгжилттэй 11, хугацаа болоогүй 53, хэрэгжилт **94.5** хувьтай байна.

Хяналтад байгаа 495 хэрэгжилтээс хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн 53 нь дараах байна. Агаарын тээвэрлэгч тухайн чиглэлд нисэх хүсэлтээ 2016-2020 оны хооронд ИНЕГ-НААХЗА-д ирүүлээгүй 49 байна. Хэрэгжих хугацаа болоогүй 4 арга хэмжээ байна.

2.11. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

2020 оны жилийн эцсийн байдлаар Төрийн нарийн бичгийн даргын 106 тушаалын 151 үүрэг даалгавраас 100 хувийн биелэлттэй 137, 70 хувийн биелэлттэй 7, хугацаа болоогүй 7 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **98.5** хувь байна.

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Биелэлт хувь
			100	70	30	Хүчингүй болсон			
1	ТЗУГ	15	13	-	-	-	2	100.0	
2	БТГ	28	25	-	-	2	1	100.0	
3	ХШҮДАГ	46	42	3	-	-	1	98.0	
4	АЗБХЗГ	46	40	4	-	-	2	97.3	
5	АТБХЗГ	7	7	-	-	-	-	100.0	
6	ТЗДТБХЗГ	21	21	-	-	-	-	100.0	
7	АгТБХЗГ	5	4	-	-	-	1	100.0	
8	ЗТХТ	3	3	-	-	-	-	100.0	
9	АҮҮТ	1	1	-	-	-	-	100.0	
10	ГТХЗНТ	1	1	-	-	-	-	100.0	
11	УБТЗ	6	6	-	-	-	-	100.0	
12	МТЗ	3	3	-	-	-	-	100.0	
13	ДЗ	1	1	-	-	-	-	100.0	
НИЙТ		183	167	7	-	2	7	98.7	
		151	137	7	-	2	7	98.5	

2.12. Засгийн газрын хуралдаанаар 2020 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

2020 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх 24 асуудлыг төлөвлөсөн ба хэлэлцүүлсэн 11, 70 хувийн 2, 30 хувийн 2, үнэлэх боломжгүй 9 асуудлын дундаж хэрэгжилт **86.6** хувь байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хэлэлцэх шаардлагагүй	Биелэлт хувь
			100	70	30	0	Үнэлэх боломжгүй		
1	БТГ	24	11	2	2			86.6	
2	ТЗДТБХЗГ	11	5	1			5	95.0	
3	АТБХЗГ	4	2	1	1			75.0	
4	АЗБХЗГ	3	3					100.0	
5	АгТБХЗХ	6	1		1		4	65.0	
Нийт		24	11	2	2		9	86.6	

Засгийн газрын хуралдаанд 2020 онд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 24 асуудлыг Бодлого, төлөвлөлтийн газар бусад бодлогын хэрэгжилтийн газруудтай хамтран хэрэгжүүлж ажиллалаа. Үнэлэх боломжгүй арга хэмжээнд Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг Заасгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсанаар хуулийг дагаж хэрэгжүүлэх багц, дүрэм, журмууд хуралдаанаар хэлэлцүүлэгдээгүй байна.

2.13. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

2020 онд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөгөөр 23 асуудал, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлтээр 10 арга хэмжээг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 2020 оны төлөвлөгөөнд 1 арга хэмжээг давхардуулан батласан ба тус арга хэмжээг хэрэгжилтэдтооцоогүй байна. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтэд бүрэн хэрэгжсэн 25, хэлэлцүүлэх шаардлагагүй болсон 7 арга хэмжээний дундаж үнэлгээ 2020 оны жилийн эцсийн байдлаар **100** хувь байна.

2020 оны Сайдын зөвлөлийн хуралдаанаар нийт 32 асуудлын хүрээнд нэгжүүдэд өгөгдсөн 35 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тус бүр авч үзвэл:

№	Хугацаа /улирлаар/	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Хэлэлцүүлэх шаардлагагүй болсон	Биелэлт /хувиар/
			100	70	30	0		
1	БТГ	6	5				1	100.0%
2	ТЗУГ	3	3					100.0%
3	АЗБХЗГ	4	3				1	100.0%
4	АТБХЗГ	4	3				1	100.0%
5	ТЗДТБХЗГ	4	2				2	100.0%
6	АгТБХЗГ	6	5				1	100.0%
7	ХШҮДАГ	8	7				1	100.0%
	Нийт	35	28				7	100.0%

2.14. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт:

2020 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаа 2017 оны 4 шийдвэрийн 12 үүрэг даалгавар, 2018 оны 7 шийдвэрийн 25 үүрэг даалгавар, 2019 оны 16 шийдвэрийн 43 үүрэг даалгавар, 2020 оны 22 шийдвэрийн 94 үүрэг даалгавар буюу яамны газар, болон харъяа байгууллагуудад нийт 49 шийдвэрийн 176 үүрэг даалгаврыг зөвлөлийн шийдвэрээр өгсөн байна.

Хяналтад байгаа СЗХ-аас гарсан 27 шийдвэр өмнөх онуудын үүрэг даалгавар ба хэрэгжилт 79.2% байна.

№	Хугацаа, /оноор/	Шийдвэрийн тоо, хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
			100	70	30	0		
1	2017	4	3	1	-	-	-	75,0%
2	2018	7	3	3	1	-	-	77,1%
3	2019	16	4	10	1	-	1	81,3%

4	2020	22	12	7	1	-	2	86,0%
Нийт		49	22	21	3	-	3	81,7%

Доорх хүснэгтээр яамны газар болон харьяа байгууллагуудад өгөгдсөн 176 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хувиар үзүүлэв.

№	Газар, хэлтсийн нэр	Хариуцсан асуудлын тоо, хэмжээ	Үнэлгээ хувиар				Хугацаа болоогүй	Биелэлт, хувиар
			100%	70%	30%	0%		
1	ТЗУГ	3	2	-	-	-	1	100.0
2	БТГ	20	15	1	2	-	2	90.5
3	ТЗДТБХЗГ	14	10	1	-	-	3	97.2
4	АЗБХЗГ	11	6	2	1	-	2	85.5
5	АТБХЗГ	21	8	10	1	-	2	80.5
6	ХШУДАГ	18	13	1	1	-	3	93.3
7	АгТБХЗГ	20	8	8	2	-	2	78.8
8	ИНЕГ	34	17	11	5	-	1	79.4
9	“ЗТХТ” ТӨҮГ	5	3	1	-	-	1	92.5
10	“АТУТ” ТӨҮГ	5	2	1	1	-	1	75.0
11	МТЗ	5	1	-	2	-	2	53.3
12	УБТЗ ХНН	3	1	1	-	-	1	85.0
13	МИАТ	1	1	-	-	-	-	100.0
14	Далайн захиргаа	4	1	1	1	-	1	66.6
15	ГТХЗНТ	3	1	-	-	-	2	100.0
16	ХОБК	1	-	-	-	1	-	0.0
17	“Нортерн рейлвейс” ХХК	1	-	-	-	1	-	0.0
18	ИНУТ	2	-	1	1	-	-	50.0
19	НТОЗШША	4	-	1	2	-	1	43.3
Дүн		176	89	40	19	2	26	84.1

Сайдын зөвлөлийн хуралдааны 49 шийдвэрээр 19 газар, хэлтэс болон харьяа байгууллагад 176 үүргийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба 2020 оны жилийн эцсийн байдлаар дундаж хэрэгжилт **84.1** хувь байна.

2.15. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас хийж буй ажлын явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ.

Яамны болон харьяа байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн нээлттэй, ил тод байдлыг хангах 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлттэй хэрэгжилттэй байна. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлэв.

№	Газрын нэр	Хэрэгжүүлэх заалт ын тоо	Биелэлт, хувиар					Шалгуур үзүүлэлтэд хамаарахгүй	Дундаж хувь
			100%	70%	30%	0%			
1	ТЗУГ	10	9	1	-	-	-	97.0	
2	БТГ	6	3	2	-	-	1	88.0	
3	АЗБХЗГ	7	5	2	-	-	-	91.4	
4	АТБХЗГ	7	7	-	-	-	-	100.0	
5	ТЗДТБХЗГ	7	6	-	-	-	1	100.0	
6	АгТБХЗГ	7	5				2	100.0	
7	ХШУДАГ	3	2	1				90.0	
8	ИНЕГ	14	12	1	-		1	97.7	
9	ЗТХТ	14	8	4	-	-	2	90.0	
10	АТҮТ	14	12	1	-	-	1	97.7	
11	ДЗ	14	10	1			3	97.2	
12	МТЗ	14	11	1	-		2	97.5	
13	ГТХЗНТ	14	10	1			3	97.7	
14	МИАТ	14	9	1			4	97.0	
15	НТОЗШША	14	9	2	-		3	94.5	
Нийт		159	118	18	0	0	23	96.2	
14 үзүүлэлт		14	14	-	-	-	-	100.0	

2020 оны жилийн эцсийн байдлаар Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт хавсаргав. /Хавсралт 5/

2.16. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2020 оны 1 дүгээр улиралд шинэчлэн байгуулсан бөгөөд шинэчлэгдэн байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 6 зорилтын 35 арга хэмжээ тусгагдан, 2020 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 19 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ, 50 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, 30 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ болон газрын маргаан болон санхүүжилтгүй улмаас хэрэгжүүлэх боломжгүй 2 арга хэмжээний дундаж **85.4** хувийн хэрэгжилттэй байна.

“Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг газар тус бүрээр гаргаж үзүүлэв. (давхардсан тоогоор)

№	Хариуцагч нэгж, байгууллага	Нийт	Үнэлгээг хувиар үзүүлбэл						ҮБ	Хувь
			100	90	70	50	30	0		



1	БТГ	10	10							100.0
2	АЗБХЗГ	11	4	6		1				90.0
3	АТБХЗГ	18	13			1	1		3	92.0
4	ТЗДТБХЗГ	9	6		1		1		1	87.5
5	ХШУДАГ	1	1							100.0
6	УБТЗ ХНН	4	3				1			82.5
7	АТҮТ ТӨҮГ	1	1							100.0
8	Нийслэлийн харьяа байгууллага	41	20	3	10	3	3		2	82.3
Хариуцагчийн арга хэмжээ		93	58	9	11	5	6		6	87.7
ХШҮ-ний арга хэмжээ		35	35	19	5	7	2	2		85.4

2020 оны жилийн эцсийн байдлаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 35 арга хэмжээний хэрэгжилтийг хангахаар яамны 5 газар, “АТҮТ” ТӨҮГ, “УБТЗ” ХНН, Нийслэлийн 12 байгууллагуудын 93 арга хэмжээний дундаж 87.7 хувь байна.

Үүнээс яамны 5 газар тус бүрийн “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 47 арга хэмжээг үнэлж, хүснэгтээр харуулбал:

№	Хариуцагч	Нийт	Үнэлгээ, хувиар						ҮБ	Дундаж хувь
			100	90	70	50	30	0		
1	БТГ	10	10	-	-	-	-	-	-	100.0
2	АЗБХЗГ	11	4	-	-	1	-	-	-	90.0
3	АТБХЗГ	18	13	-	-	1	1	-	3	92.0
4	ТЗДТБХЗГ	9	6	-	1	-	1	-	1	87.5
5	ХШУДАГ	1	1	-	-	-	-	-	-	100.0
Нийт		49	34	-	1	2	2	-	4	88.7

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биеэлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт 3/

2.17. Зам, тээврийн хөгжлийн сайд болон аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2020 оны хамтын ажиллагааны гэрээний зорилго нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн зам, тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, хүн амын амьдралын таатай нөхцлийг хангах, иргэдийн ая тухтай зорчих боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү гэрээгээр Зам, тээврийн хөгжлийн сайд зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн үйл ажиллагаанд салбарын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, улсын төсөв, Хөгжлийн банк болон гадаадын зээл тусламжаар орон нутагт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн ба аймгийн Засаг дарга нар авто зам, автотээвэр, агаарын тээвэр, төмөр зам, усан замын тээврийн чиглэлээр тодорхой үүргүүдийг хүлээсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2020 оны хамтын ажиллагааны гэрээнд нийт 648 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн биелэлттэй буюу бүрэн хэрэгжсэн 305, 90 хувийн биелэлттэй 18, 70 хувийн биелэлттэй буюу үр дүн гарсан 88, 50 хувийн биелэлттэй 15, 30 хувийн биелэлттэй 95, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 47, гэрээгээр төлөвлөсөн боловч үнэлгээнд тооцох боломжгүй 80 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **73.7** хувьтай байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг аймаг тус бүрээр авч үзвэл:

№	Аймаг	Нийт	Үнэлгээг хувиар үзүүлбэл							Хувь
			100%	90%	70%	50%	30%	0%	ҮБ	
1	Архангай	30	19	-	4	-	5	2	-	77.7
2	Баян-Өлгий	30	13	-	5	3	7	1	1	69.3
3	Баянхонгор	24	16	1	1	-	1	3	2	81.4
4	Булган	38	16	1	3	1	3	3	11	75.5
5	Говь-Алтай	24	12	1	6	2	2	-	1	81.3
6	Говьсүмбэр	32	12	-	4	1	5	2	8	70.0
7	Дархан	32	17	-	4	1	3	1	6	81.5
8	Дорноговь	32	22	-	2	-	2	-	6	92.3
9	Дорнод	38	19	2	10	-	1	-	6	87.8
10	Дундговь	24	11	4	2	1	3	1	2	79.1
11	Завхан	24	10	1	2	1	7	2	1	64.8
12	Орхон	32	13	1	2	-	6	2	8	71.2
13	Өвөрхангай	24	12	-	3	1	4	1	3	75.2
14	Өмнөговь	26	13	3	1	1	5	2	1	73.6
15	Сүхбаатар	32	10	2	4	-	5	3	8	67.1
16	Сэлэнгэ	38	13	1	3	2	4	14	1	49.2
17	Төв	32	17	-	4	-	2	3	6	78.5
18	Увс	30	15	1	7	-	6	-	1	77.9
19	Ховд	30	12	-	8	-	9	1	-	67.7
20	Хөвсгөл	38	21	-	4	-	5	-	8	84.3
21	Хэнтий	38	12	-	9	1	10	6	-	57.4
Нийт		648	305	18	88	15	95	47	80	73.7

Зам, тээврийн хөгжлийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2020 оны хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг 2019 оны гэрээний биелэлттэй харьцуулахад 10.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аймгуудын Засаг дарга нартай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 онд хамтран ажиллах гэрээний хамгийн сайн үнэлэгдсэн аймгаар Дорноговь аймаг 92.3 хувиар үнэлэгдсэн бол Сэлэнгэ аймаг хамгийн бага буюу 49.2 хувиар үнэлэгдсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт 4/

2.18. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлангийн хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 92 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2020 оны 1-4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Нийт 92 төрийн байгууллага, хуулийн этгээд байна. Үүнд: Улсын төсвийн байгууллага 4, Төсөл, арга хэмжээ 13, Төрийн өмчит үйлдвэрийн газар 50, Төрийн өмчит хувьцаат компани 24, Хувь нийлүүлсэн нийгэмлэг 1.

Нэгдсэн дүгнээр 2020 онд Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн байгууллага, хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт **91.7** хувьтай гарлаа. Тайлант онд шилэн дансны цахим системд бүртгэлтэй 95 байгууллага, хуулийн этгээдээс Өмнөговь аймгийн “Авто тээврийн төв” ТӨҮГ давхар цэс бүртгэгдсэн, Тээврийн хэрэгслэлийн оношлогоо, хяналт зохицуулалтын төвийн дарга /хуучин нэрээр/ ЗГ-ын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн, “Авто зам тоног төхөөрөмж түрээс” ТӨҮГ Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор татан буугдсан байсныг Сангийн яамны Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтэст Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 03/4859 тоот албан бичгийг хүргүүлж бүртгэлээс хасуулав. “Авто импекс” ХК цахим системд бүртгэлтэй байх боловч мэдээлэл огт байршуулаагүй явж ирсэн байна.

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан Дотоод аудит хийх тухай 09-01/53 дугаар Удирдамжийн хүрээнд харьяа байгууллага, газрууд шилэн дансны хэрэгжилтэд дотоод хяналт хийж ажилласан байна. 2020 оны 4 дүгээр улиралд Сангийн яамнаас шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн төрөл заалт нэмэгдэж өөрчлөлт орсоныг нөхөж оруулсан, биелэлт 100 хувьтай гарсан байна. Харьяа газруудад гарсан нийтлэг зөрчигдөж байгаа заалтууд байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
- Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Санхүүгийн тайлан
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтийн төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар
- Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт зэргийг хугацаа хоцроож оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.1.2, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.12, 3.1.13, 4.1.2, 4.1.4, 4.1.5, 4.1.9, 4.1.15 дахь заалтууд зөрчигдсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг улирал бүр Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдлийн удирдлагын газарт хүргүүлж ажилласан.

2.19. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 28 арга хэмжээний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар **95.0** хувийн хэрэгжилттэй гэж дүгнэлээ.

“Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 74 дүгээр тушаалаар батлуулсан ба уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр:

Зам, тээврийн хөгжлийн яамны “Сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамны сургалтын төлөвлөгөөний дагуу яамны албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор нийт 27 сургалтын арга хэмжээ төлөвлөснөөс 15 сургалтыг зайнаас болон танхимаар зохион байгуулсан. Сургалтад нийт 307 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Ковид-19 цар тахлын улмаас гадаад сургалтад албан хаагчдыг хамруулаагүй бөгөөд 4 албан хаагч мэргэшил дээшлүүлэх зорилгоор магистрын сургалтад хамрагдаж байна.

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 19 сая төгрөгийг төсөвлөсөн боловч, яамны төсөвт сургалтын зардал суугаагүй тул 240,000 төгрөгийн гүйцэтгэлтэй, бусад сургалтыг Удирдлагын академи болон харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Төлөвлөгөөний дагуу яамны албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор давхардсан тоогоор яам болон харьяа байгууллага нийт 307 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Яамны



нийт албан хаагчид мэдлэг, чадвар дээшлүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх ямар нэг сургалтад бүрэн хамруулсан.

Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар БНСУ-ын Техник, технологийн их сургуулийн магистрын сургалтад 1, БНХАУ-ын Бээжингийн зам харилцааны их сургуулийн “Төмөр замын тээврийн менежмент”-ийн магистрын сургалтад 1 албан хаагч суралцан төгссөн. БНХАУ-ын Далианы далайн их сургуулийн Усан замын тээврийн эдийн засаг, менежментийн сургуулийн магистрын сургалтад 1, БНСУ-ын Сөүл хотын шинжлэх ухаан, технологийн их сургуулийн магистрийн сургалтад 1, БНХАУ-ын Зүүн өмнөдийн Их сургуулийн магистрын, Япон улсын Гифүгийн их сургуулийн авто замын хөрөнгийн менежментийн магистрын тэтгэлэгт сургалтад 1, Австрали улсын Гриффит их сургуулийн магистрын сургалтад 1, нийт 4 албан хаагч суралцаж байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний дагуу жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв: Үүнд:

Яамны төрийн захиргааны нийт 12 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон ахиулан олгох, төрийн үйлчилгээний 7 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/42 дугаар тушаалаар шийдвэрлүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны Б/18 дугаар тушаалаар төрийн захиргааны 49 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгов.

Албан хаагчдын ээлжийн амралт, тэтгэвэр, буцалтгүй тусламж олгох зэрэг асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад шийдвэр, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байгаа ба 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 133 албан хаагчид ээлжийн амралтын олговор олгогдсон ба, 25 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгов.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, албан хаагчид ажлын байран дээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг хангаж, эмчийн ажлын байрыг баталгаажуулан ажиллуулж байна.

Хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад суралцах боломжийг хангаж, 6 албан хаагчид цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлэсэн.

Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэнд, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглох боломжоор хангасан. Жингийн илүүдэлтэй, зүрх, судасны өвчтэй, даралт ихсэх өвчтэй албан хаагчдын судалгааг гаргасны үндсэн дээр нийт 28 албан хаагчийг фитнес клубт 70 хувийн хөнгөлттэйгөөр 3 сарын хугацаанд хичээллэх боломжоор хангасан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулах үүднээс өндөржүүлсэн бэлэн байдлын үед тээвэр зохион байгуулалтыг амжилттай зохион байгуулсан нийт 4 албан хаагчийг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамруулсан.

Гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын үед мэргэжлийн ур чадвар гаргаж, хүнд төвөгтэй даалгаврыг амжилттай биелүүлсэн албан хаагчдыг холбогдох журмын дагуу 1 хүртэлх сарын цалингаар шагнаж, урамшуулсан.

Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэнд, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, яамны нийт албан хаагчдыг хамарсан яамны болон салбарын 5 төрөлтийн аварга шалгаруулах тэмцээн, идэвхитэй амралтыг зохион байгуулсны зэрэгцээ албан хаагчдыг долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглох боломжоор хангасан.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, албан хаагчид ажлын байран дээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг хангаж, эмчийн ажлын байрыг баталгаажуулан ажиллуулж байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсаргав. /Хавсралт 6/

2.20. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Зам, тээврийн хөгжлийн яамны Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 16 үзүүлэлтээс 35 үзүүлэлт нь 100% болон түүнээс дээш хувиар биелж, 7 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Зорилтот түвшингээс илүү гарсан үзүүлэлтүүдийг 100% гэж дүгнэвэл Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар **83,8** хувийн биелэлттэй байна.

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Суурь үзүүлэлт /2016 он/	2020 он		
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Хувь
1	Тээвэрлэсэн ачаа (мян.тонн)	Автотээвэр	20406.2	23413.3	30454.9	130.0
		Төмөр замын тээвэр	19989.1	23000.0	30001.2	130.4
		Агаарын тээвэр	3.1	3.4	2.74	80.6
2	Дамжин өнгөрөх (транзит) ачаа (мян.тонн)	Төмөр замын тээвэр	2362.3	3588.0	4278.1	119.2
3	Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	3997.7	4586.7	4685.3	102.1
		Төмөр замын тээвэр	12371.0	14120.9	19167.6	135.7
		Агаарын тээвэр (мян.тонн/км)	8075.5	8037.3	8100	100.8
4	Зорчигчдын тоо (мян.хүн)	Автотээвэр	260680.6	242152.10	124 100	51.2
		Төмөр замын тээвэр	2645.5	2750.0	1965.75	71.5
		Усан замын тээвэр	19.0	21.9	31.1	142.0
		Агаарын тээвэр	673.2	955.5	447.5	46.8
5	Зорчигч эргэлт (сая хүн/ км)	Автотээвэр	1959.9	2329.0	2178	93.5
		Төмөр замын тээвэр	955.5	980.0	579.3	59.1
		Агаарын тээвэр	1156.5	1559.1	659.57	42.3
		Автотээвэр	497.1	577.9	564.38	97.6

6	Тээвэрлэлтийн орлого (тэрбум төгрөг)	Төмөр замын тээвэр	436.8	545.1	775.9	142.3
		Агаарын тээвэр	287.3	373.0	164.1	43.9
7	Зам, тээврийн салбарт шинээр нэвтрүүлсэн техник, технологийн тоо	Зам, тээвэр	5	8	8	100
8	Нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон аймгийн төвийн тоо	Авто зам	15	21	17	80.9
9	Олон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний урт (өссөн дүнгээр) (км)	Авто зам	6239.8	7948	7441	93.6
10	Шинээр ашиглалтад оруулах замын урт (км) (өссөн дүнгээр)	Авто зам	483.37	2165.87	2117.3	97.7
		Төмөр зам /гол/	1816.0	2127	1949.4	91.7
11	Шинээр ашиглалтад орсон гүүрийн урт (м) (өссөн дүнгээр)	Авто зам	562.7	1834.5	1984.75	108.2
12	Тээврийн чиглэлийн тоо (өссөн дүнгээр)	Автотээвэр	391	396	247	62.3
		Олон улсын нислэг	16	35	34	97.1
13	Буулт, хөөрөлтийн тоо (мян.)	Агаарын тээвэр	11.682	16.893	7.284	43.1
14	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо (мян.)	Агаарын тээвэр	99.21	124.45	71.4	57.3
15	Тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт (өссөн дүнгээр)	Автобус	43	400	163	40.7
		Зүтгүүр	162	182	163	89.5
		Ачааны вагон	6172.0	7435.0	6049	81.3
		Зорчигчийн вагон	342.0	248.0	344	138.7
		Агаарын хөлөг	24	43	36	83.7
16		Автовокзал	2	19	25	131.6

	Вокзал буудлын тоо (өссөн дүнгээр)	Төмөр замын буудлын тоо	86	90	79	87,8
		Нисэх буудлын тоо	24	25	25	100

Зам, тээврийн салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй статистик мэдээллийн хамт хавсаргав. /Хавсралт 2/

ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Тайлант хугацаанд яамны 2020 оны үйл ажиллагааг яам, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зам, тээврийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, СЗХ-наас гарсан шийдвэр, аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт зэрэг 20 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 107 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан байна.

2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХЭГ, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газруудад тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан.

3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны үйл ажиллагааг дүгнэвэл:

1	Үзүүлэлт	Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	96.9	0.6	2,7
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	84.6		
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	92.5		
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	83.8		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	86.1	0.2	0,9
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	95.0		
Байгууллагын нээлттэй	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100.0	0.2	0,9
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	91.7		

байдлын үнэлгээ	3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ			1.0	4.5

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас гаргадаг, 2020 оны Хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар хийхээр шийдвэрлэсэн.

Ерөнхий үнэлгээ хийсэн аргачлал:

$$\Sigma = 0.05 * [(96,9 + 84,6 + 92,5 + 83,8) \div 4 * 0.6 + (86,1 + 95,0) \div 2 * 0.2 + (100,0 + 91,7) \div 2 * 0.2] = 0,05(53,5 + 17,7 + 19,2) = 4.5$$

ГУРАВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт удаашралтай байгаа, хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийг 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр хугацаа алдалгүй авч ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудад;
2. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу ЗГХЭГ-аас баталж ирүүлсэн аргачлал, загварын баримтлан яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний хэрэгжүүлэх хугацааг сар, улирлаар тогтоон улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлын хүрэх түвшинг улирал тус бүрээр тодорхой төлөвлөх, нэгжүүдийн оролцоог ялгаатай тогтоохыг яамны газар, харьяа агентлаг, байгууллагуудад;
3. Бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч, санхүүжилтийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгуулж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;
4. Зам, тээврийн салбарын хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны эхний хагаст багтаан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын чуулганаар батлуулан эдгээр хуулиудтай уялдуулан боловсруулахаар хүлээгдэж буй хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтцийн шинэчлэл хийх ажлуудыг түргэвчлэхийг яамны холбогдох газруудад;
5. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудыг яаралтай дуусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;
6. Санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжих боломжтой хууль, эрх зүйн орчинг сайжруулах, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, журам, мастер төлөвлөгөө, төлөвлөгөө боловсруулж батлуулах, судалгаа хийх, байнгын ажиллагаатай ажлыг хэсгүүдийг

хуралдуулах зэрэг арга хэмжээнүүдийг хугацаанд нь хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан 2021 онд багтаан хэрэгжүүлэх ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудад;

7. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-үүдийн хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай байна. 2020 оны 171 дугаар тогтоолоор батлагдсан “Тээврийн ухаалаг ситемийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан үндэсний хөтөлбөрийн , хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой заасан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах талаар Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;
8. “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хугацаа дууссантай холбогдуулан Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу бодлогын бичиг баримт нь тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөгдсөн эсэх, ямар үр нөлөө үзүүлсэн талаар эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, дүнг тус журмын хавсралтын дагуу гарган тайлагнах ажлыг зохион байгуулахыг ИНЕГ, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт;